БАТЛАВ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА
С.СҮХБОЛД

2024 он 01 сар 26 өдөр

# МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

## ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН 2024 ОНЫ ХЭРЭГЦЭЭНД ХУДАЛДАН АВАХ ДҮРЭМТ ХУВЦАС, ЯЛГАХ ТЭМДЭГ, МАТЕРИАЛЫГ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

| | |
|---|---|
| Тендер шалгаруулалтын нэр: | *Цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материал* |
| Тендер шалгаруулалтын дугаар: | |

2024 он

# I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)


I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ) ... 1
1. Тендерийн цар хүрээ ... 1
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг ... 1
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж ... 1
4. Сонирхогч этгээд, оролцогч ... 2
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ ... 2
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл ... 2
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг ... 3
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах ... 3
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт ... 3
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл ... 3
11. Тендерийн иж бүрдэл ... 4
12. Тендерийн жишиг маягтууд ... 5
13. Хувилбарт санал ... 5
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг ... 5
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг ... 5
16. Чадавхын болон туршлагын шаардлага ... 7
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ... 7
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ... 8
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт ... 8
20. Тендерийн валют ... 9
21. Тендер хүчинтэй байх хугацаа ... 9
22. Тендерийн баталгаа ... 9
23. Тендер баталгаажуулах, илгээх ... 9
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа ... 10
25. Тендерийн талаар тодруулга авах ... 10
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх ... 10
27. Тендерийг үнэлэх ... 10
28. Арифметик алдааг залруулах ... 10
29. Оролцогчид давуу эрх олгох ... 11
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ... 11
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох ... 11
32. Тендерийг эрэмбэлэх ... 11

33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах ........ 11
34. Мэдэгдэл хүргүүлэх ........ 11
35. Гүйцэтгэлийн баталгаа ........ 12
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах ........ 12

## I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

### А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

| | | |
|---|---|---|
| **1. Тендерийн цар хүрээ** | 1.1. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “**Хууль**” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “**бараа**” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.2. | Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана. |
| | 1.3. | Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ. |
| | 1.4. | Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана. |
| **2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг** | 2.1. | Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| **3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж** | 3.1. | Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. |
| **4. Худалдан авах ажиллагааны цахим систем** | 4.1. | Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна. |
| **5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх** | 5.1. | Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ. |

|  |  |  |
| --- | --- | --- |
|  | 5.2. | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, $20^1$, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна. |
| **6. Сонирхогч этгээд, оролцогч** | 6.1. | Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ. |
|  | 6.2. | Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна. |
|  | 6.3. | Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй. |
|  | 6.4. | Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна. |
|  | 6.5. | ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй. |
| **7. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ** | 7.1. | Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. |
|  | 7.2. | Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй. |
|  | 7.3. | Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна. |
|  | 7.4. | ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй. |
|  | 7.5. | Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ. |
| **8. Нийлүүлэх барааны гарал үүсэл** | 8.1. | ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. |

**Б.АГУУЛГА**

**9. Тендер шалгаруулалтын баримт бичиг**

9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.

**10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**

10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

**11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**

11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

## B. ТЕНДЕР БЭЛТГЭХ

**12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

**13. Тендерийн иж бүрдэл**

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;

13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;

13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

**14. Тендерийн жишиг маягтууд**

14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.

**15. Хувилбарт санал**

15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

**16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг**

16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.

16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

**17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**

17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн Маягт 2-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.

17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.

17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.

17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.

17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;

17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;

17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.

17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.

17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

**18. Чадавхын болон туршлагын шаардлага**

18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

**19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**

19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

**20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**

20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

**21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**

21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.

21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.

21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

**22. Тендерийн валют**

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

**23. Тендер хүчинтэй байх хугацаа**

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

**24. Тендерийн баталгаа**

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.

24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

## Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

**25. Тендер баталгаажуулах, илгээх**

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

**26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

## Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

**27. Тендерийн талаар тодруулга авах**

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

**28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

**29. Тендерийг үнэлэх**

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

**30. Арифметик алдааг залруулах**

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

| | |
|---|---|
| **31. Давуу эрх олгох** | 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно. |
| | 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй. |
| | 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай. |
| **32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** | 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ. |
| **33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** | 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална. |
| | 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ. |
| | 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална. |
| **34. Тендерийг эрэмбэлэх** | 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална. |
| **35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах** | 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална. |
| | 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ. |
| | 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно. |

## Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

| | |
|---|---|
| **36. Шийдвэр хүргүүлэх** | 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ. |

**37. Гүйцэтгэлийн баталгаа**

37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

37.2. Гүйцэтгэлийн баталгааг "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-д нийцүүлэн гаргана.

**38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**

38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

## II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
|---|---|
| ТШЗ 1.1 | Захиалагч: ***Цагдаагийн ерөнхий газар*** |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын нэр: ***"Цагдаагийн алба хаагчдын 2024 оны хэрэгцээнд худалдан авах дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материал"*** |
| ТШЗ 1.1 | Тендерийн урилгын дугаар: ЦЕГСААА/20240102001 |
| ТШЗ 1.2 | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий нийт 49 багцаас бүрдэнэ. |
| ТШЗ 1.3 | -Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой 1-27 дугаар багцад тендер ирүүлэх оролцогчийн Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд тендер санал болгосон тухайн багцад хамааралтай доорх үйл ажиллагааны чиглэл тусгагдсан байна. Үүнд:<br>✓ Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн, оёдлын үйлдвэрлэл;<br>✓ Арьс, арьсан ширэн бүтээгдэхүүн, савхин эдлэлийн үйлдвэрлэл;<br>✓ Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл;<br>✓ Гутал үйлдвэрлэл;<br>✓ Хатгамалын үйлдвэрлэл. |
| | **Нэг:** Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах боломжтой бараанд 1-27 дугаар хүртэлх багцууд хамаарна. Үүнд:<br>***Дотоодын багц №1: Албаны саравчтай малгай (хар хөх, цагаан өнгөтэй);***<br>***Дотоодын багц №2: Каракуль малгай;***<br>***Дотоодын багц №3: Өвлийн малгай (хиймэл үстэй);***<br>***Дотоодын багц №4: Өвлийн малгай (хиймэл үстэй);***<br>***Дотоодын багц №5: Албаны китель өмд, китель юбка;***<br>***Дотоодын багц №6: Өдөр тутмын хүрэм, өмд;***<br>***Дотоодын багц №7: Каракуль захтай болон эрэгтэй савхин хүрэм;***<br>***Дотоодын багц №8: Савхин хүрэм (эрэгтэй, эмэгтэй);***<br>***Дотоодын багц №9: Өвлийн хүрэм, өмд (каракуль болон хиймэл үсэн захтай);***<br>***Дотоодын багц №10: Өвлийн хүрэм, өмд (хиймэл үсэн захтай);***<br>***Дотоодын багц №11: Хээрийн хүрэм, өмд;***<br>***Дотоодын багц №12: Хээрийн хүрэм, өмд;***<br>***Дотоодын багц №13: Борооны цув;***<br>***Дотоодын багц №14: Ёслолын цамц (богино ханцуйтай);***<br>***Дотоодын багц №15: Албаны цамц (богино ханцуйтай);***<br>***Дотоодын багц №16: Өдөр тутмын цамц (урт ханцуйтай);***<br>***Дотоодын багц №17: Өдөр тутмын цамц (урт ханцуйтай);***<br>***Дотоодын багц №18: Ноосон цамц;***<br>***Дотоодын багц №19: Өвлийн оймстой гутал;***<br>***Дотоодын багц №20: Богино түрийтэй гутал;***<br>***Дотоодын багц №21: Пүүзэн ботинк;***<br>***Дотоодын багц №22: Ёслолын саан бүс;***<br>***Дотоодын багц №23: Ёслолын саан бүс, саан мөрдэс;***<br>***Дотоодын багц №24: Албаны мөрдэс;***<br>***Дотоодын багц №25: Тэлээ;***<br>***Дотоодын багц №26: Зангиа (эрэгтэй);***<br>***Дотоодын багц №27: Ханцуйн бэлгэдэл тэмдэг (зангуутай, зангуугүй).*** |

| | |
|---|---|
| | ✓ Цагдаагийн алба хаагчид хэрэгцээт дүрэмт хувцсыг төлөвлөсөн хугацаанд олгох, албаны бэлэн байдлыг хангах, барааны бэлтгэх хугацааг богиносгох зорилгоор өвлийн малгай (хиймэл үстэй), савхин хүрэм (эрэгтэй), өвлийн хүрэм, өмд (хиймэл үсэн захтай), хээрийн хүрэм өмд, өдөр тутмын цамц (урт ханцуйтай), ёслолын саан бүс зэргийг дотоодын үйлдвэрлэгчдийн хүчин чадал, ажиллах хүчинтэй уялдуулан тус бүрийг нь 2 багц болгон задалсаныг анхаарна уу.<br><br>**Хоёр:** Дотооддоо үйлдвэрлэх боломжгүй барааны багцад 28-49 дугаар хүртэлх багцууд хамаарна. Үүнд:<br><br>***Багц №28: Берет малгай;***<br>***Багц №29: Албаны хүрэм;***<br>***Багц №30: Гэрэлтүүлэгчтэй хантааз (зуны);***<br>***Багц №31: Гэрэлтүүлэгчтэй хантааз (өвлийн);***<br>***Багц №32: Хүзүүвч;***<br>***Багц №33: Дан өмд;***<br>***Багц №34: Тоногтой бүс;***<br>***Багц №35: Цамцны мөрдөс;***<br>***Багц №36: Цолны тэмдэг;***<br>***Багц №37: Ёслолын болон өдөр тутмын малгайн тэмдэг, захны таних тэмдэг;***<br>***Багц №38: Зангианы хавчаар, ёслолын бээлий;***<br>***Багц №39: Ёслолын саан унжлага;***<br>***Багц №40: Алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэг (читон);***<br>***Багц №41: Өвлийн хувцасны хар хөх даавуу;***<br>***Багц №42: Хээрийн хувцасны хар хөх даавуу;***<br>***Багц №43: Өдөр тутмын хувцасны хар хөх даавуу;***<br>***Багц №44: Албаны цамцны цэнхэр даавуу;***<br>***Багц №45: Өдөр тутмын цамцын хар хөх даавуу;***<br>***Багц №46: Дулаалгын материал (тенсулейт);***<br>***Багц №47: Өмдний дотор даавуу;***<br>***Багц №48: Ёслолын бүс болон мөрдэсний саан тууз;***<br>***Багц №49: Ёслолын бүсний арал.*** |
| **ТШЗ 1.4** | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"*** |
| **ТШЗ 2.1** | Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Улсын төсвийн урсгал зардал.*** |
| **ТШЗ 2.1** | Нийт төсөвт өртөг: ***20,857,959,000.00 (Хорин тэрбум найман зуун тавин долоон сая есөн зуун тавин есөн мянга) төгрөг.*** |

| | |
|---|---|
| ТШЗ 2.1 | ***Энэхүү тендер шалгаруулалтын 1-49 дугаар хүртэлх багц тус бүрийн төсөвт өртөг нь:***<br><br>***Багц №1: 273,294,000.00 төгрөг;***<br>***Багц №2: 34,874,000.00 төгрөг;***<br>***Багц №3: 128,205,000.00 төгрөг;***<br>***Багц №4: 130,900,000.00 төгрөг;***<br>***Багц №5: 209,600,000.00 төгрөг;***<br>***Багц №6: 222,750,000.00 төгрөг;***<br>***Багц №7: 893,100,000.00 төгрөг;***<br>***Багц №8: 854,500,000.00 төгрөг;***<br>***Багц №9: 526,400,000.00 төгрөг;***<br>***Багц №10: 438,150,000.00 төгрөг;***<br>***Багц №11: 148,750,000.00 төгрөг;***<br>***Багц №12: 148,750,000.00 төгрөг;***<br>***Багц №13: 806,400,000.00 төгрөг;***<br>***Багц №14: 166,600,000.00 төгрөг;***<br>***Багц №15: 238,000,000.00 төгрөг;***<br>***Багц №16: 265,200,000.00 төгрөг;***<br>***Багц №17: 267,436,000.00 төгрөг;***<br>***Багц №18: 973,500,000.00 төгрөг;***<br>***Багц №19: 1,206,000,000.00 төгрөг;***<br>***Багц №20: 875,000,000.00 төгрөг;***<br>***Багц №21: 1,280,000,000.00 төгрөг;***<br>***Багц №22: 103,600,000.00 төгрөг;***<br>***Багц №23: 118,800,000.00 төгрөг;***<br>***Багц №24: 231,000,000.00 төгрөг;***<br>***Багц №25: 61,600,000.00 төгрөг;***<br>***Багц №26: 96,000,000.00 төгрөг;***<br>***Багц №27: 55,100,000.00 төгрөг;***<br>***Багц №28: 230,000,000.00 төгрөг;***<br>***Багц №29: 2,853,675,000.00 төгрөг;***<br>***Багц №30: 1,026,000,000.00 төгрөг;***<br>***Багц №31: 1,026,000,000.00 төгрөг;***<br>***Багц №32: 210,000,000.00 төгрөг;***<br>***Багц №33: 678,405,000.00 төгрөг;***<br>***Багц №34: 754,000,000.00 төгрөг;***<br>***Багц №35: 370,000,000.00 төгрөг;***<br>***Багц №36: 120,000,000.00 төгрөг;***<br>***Багц №37: 79,200,000.00 төгрөг;***<br>***Багц №38: 31,770,000.00 төгрөг;***<br>***Багц №39: 398,250,000.00 төгрөг;***<br>***Багц №40: 74,000,000.00 төгрөг;***<br>***Багц №41: 407,500,000.00 төгрөг;***<br>***Багц №42: 252,000,000.00 төгрөг;***<br>***Багц №43: 215,000,000.00 төгрөг;***<br>***Багц №44: 75,000,000.00 төгрөг;***<br>***Багц №45: 487,500,000.00 төгрөг;***<br>***Багц №46: 265,500,000.00 төгрөг;***<br>***Багц №47: 110,000,000.00 төгрөг;***<br>***Багц №48: 272,000,000.00 төгрөг***<br>***Багц №49: 108,650,000.00 төгрөг*** тус тус болно. |
| **Б. АГУУЛГА** | |

<table>
<tr><td>ТШЗ 8.1</td><td>Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг:<br><br>Хүлээн авагчийн нэр: Цагдаагийн ерөнхий газар<br><br>Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж-18, Цагдаагийн ерөнхий газрын төв байрны 6 дугаар давхар, 604 тоот өрөө.<br><br>Утасны дугаар: 70191057<br><br>Цахим шуудангийн хаяг: saaa.khangamj@police.gov.mn<br><br>Тендерт оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө бичгээр гаргаж болно.<br><br>Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргаж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.</td></tr>
<tr><td>ТШЗ 11.1</td><td>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”</td></tr>
<tr><td colspan="2" align="center">B. ТЕНДЕР БЭЛТГЭХ</td></tr>
<tr><td rowspan="2">ТШЗ 12.2</td><td>Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл” байна<br><br>Оролцогч нь өөр хэл (гадаад)-ээр үйлдсэн бүх тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулгын хамт ирүүлнэ.</td></tr>
<tr><td>Тендерт оролцогч дотоодын аж ахуй эрхлэгч нь:<ul><li>Оролцогчийн ерөнхий нөхцлийг магадлахтай холбогдох Шүүхийн ерөнхий зөвлөлийн “Шүүхийн тусгай архив”-ын лавлагаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан цахим хэлбэрээр тус тус ирүүлнэ.</li><li>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр ирүүлнэ.</li><li>Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд төлөөлөх эрхээ бусдад шилжүүлэх бол итгэмжлэл гаргаж ирүүлнэ.</li></ul>Тендерт оролцогч гадаадын этгээд нь:<ul><li>Үүсгэн байгуулагдсан улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ, гадаад худалдааны лицензийг ирүүлнэ.</li><li>Түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичгийг ирүүлнэ.</li></ul></td></tr>
</table>

| | |
|---|---|
| | • Оролцогчийн ерөнхий нөхцлийг магадлахтай холбогдох “Апостиль гэрчилгээ”-г үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ.<br>• Сүүлийн 2 жил (2022, 2023)-онуудын санхүүгийн жилийн эцсийн баталгаажсан тайлангийн хуулбарыг ирүүлнэ.<br>• Гэрээний дагуу нийлүүлэх бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, хэрэглэх үед бараанд үйлдвэрлэлийн гологдол, дутагдал илэрсэн нөхцөлд уг барааны гологдол, дутагдлыг засах, шинээр солих, нөхөн олгох, засвар, үйлчилгээг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөлийн газар, эсхүл бусад төлөөлөгч бүрэн гүйцэтгэх тухай баталгааг ирүүлнэ.<br>Бүх тендерт оролцогч нар:<br>• Тендер илгээх маягт, барааны үнийн задаргаа, бараа нийлүүлэлтийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ.<br>• Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр баталгаажуулан ирүүлнэ.<br>• Тендерт оролцогч нь татвар, нийгмийн даатгалын байгууллага, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, харилцагч банк болон бусад эрх бүхий байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг бичгээр ирүүлнэ.<br>**Барааны чанарын баталгаа:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь хэсэгт заасан чанарын баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.<br>**Барааны чанарын баталгаат хугацаа нь:** Барааг захиалагч талд бүрэн хүлээлгэн өгснөөс хойш 1 жил (12 сар)-ийн хугацаанд хүчинтэй байна.<br>• Хэрэв гэрээний дагуу нийлүүлэх бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, хэрэглэх үед бараа, бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн гологдол, дутагдал илэрсэн бөгөөд энэ нь чанарын баталгаат хугацааны дотор бол бэлтгэн нийлүүлэгч нь уг бараа бүтээгдэхүүний гологдол, дутагдлыг засах, солих, нөхөн олгохтой холбогдох бүх зардлыг дангаар хариуцна. |
| **ТШЗ 15.1** | Хувилбарт санал ирүүлэхийг: ***“Зөвшөөрөхгүй”*** |
| **ТШЗ 17.4** | Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж ирүүлэх эсэх: ***“Тийм”***<br>**Барааны “загвар”-ыг ирүүлэх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:**<br>• Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж-18, Цагдаагийн ерөнхий газрын төв байрны 1 дүгээр давхарт хүлээн авна. Утас: 70191057.<br>**Барааны ”загвар”-ыг хүлээн авах огноо, цаг нь:**<br>Огноо: ***2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр***<br>Цаг:***09 цаг 00 минут***<br>Тендерээр санал болгосон барааны техникийн тодорхойлолтын 3-т “Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон |

<table>
<tr><td></td><td>итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ.” гэж заасан бараанд дагалдах шинжилгээний бичгийг ирүүлнэ.<br><br>Хэрэв “загвар”, “дагалдах шинжилгээний бичиг” ирүүлээгүй бол тендерээс татгалзана.<br><br><u>Анхааруулга:</u> Хугацаа хоцорч ирүүлсэн загварыг хүлээн авахгүй бөгөөд загвар ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</td></tr>
<tr><td>ТШЗ 17.6</td><td>Барааны хувьд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад эд зүйлсийн жагсаалт ирүүлэх эсэх, ирүүлэх бол хугацаа: <u>“Үгүй”</u></td></tr>
<tr><td>ТШЗ 18.1</td><td>Барааг дагалдах үйлчилгээг хэрэгжүүлэх хүний нөөцийн шаардлага, шалгуур үзүүлэлт: “Шаардана”<br><br>• Тендерт оролцогч нь тендер санал болгосон өөрийн багцад хамаарах барааны гэрээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх, удирдах болон хяналт тавих инженер, техник (загвар зохион бүтээгч, технологич инженер, гутал, арьс ширэн бүтээгдэхүүний инженер, химийн инженер г.м)-ийн ажилтны боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаарх мэдээллийг нотлох баримтын хамт бичгээр ирүүлэх.<br><br>Үндсэн ажилчдын мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.<br><br>Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай”<br><br>• Сүүлийн 2 жил (2022, 2023)- онуудын хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 5-аар доорх заасврын дагуу ирүүлнэ. Үүнд:<br><br>
<table>
<tr><td>Гэрээний нэр</td><td>Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас</td><td>Төсөвт өртөг</td><td>Хугацаа (эхэлсэн, дууссан)</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>
<br>• Дээрх жагсаалтаар ирүүлсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг V бүлгийн Маягт 7-аар гаргаж ирүүлнэ.<br><br>2022, 2023 оны аль нэг жилд тухайн багцад хамаарах бараа болон түүнтэй дүйцэхүйц барааг нийлүүлснийг нотлох баримтыг ирүүлнэ. Үүнд:<br><br>• Бараа нийлүүлсэн гэрээний хуулбар,<br>• Барааг хүлээлгэн өгсөн акт эсхүл гэрээг дүгнэсэн нотломжийн хуулбар,<br>• Тухайн худалдан авагчийн тодорхойлолт тус тус болно.<br><br>Бараа нийлүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шаардлага: “Шаардана”<br><br>- Эсгүүрийн хэсэгчилсэн болон нарийвчилсан огтолгооны машин;</td></tr>
</table>

| | |
|---|---|
| | *- ердийн шулуун оёдлын машин;*<br>*-оёдлын 1 зүүт нам машин;*<br>*-оёдлын 1 зүүт өндөр машин;*<br>*-оёдлын 1 зүүт хөндлөн машин;*<br>*-оёдлын 1 зүүт өндөр хүнд машин;*<br>*- хос оёоны машин;*<br>*- хавтгай болон сэнжтэй товч хадах машин;*<br>*- хэрээсний 3-5 утастай машин;*<br>*- түдүүлийн машин;*<br>*- бөхөлгөөний машин;*<br>*- гинжин хатгацтай машин;*<br>*- хажлагатай хагалбар халаас гаргадаг машин;*<br>*- зиг-заг оёоны машин;*<br>*- товчны шулуун болон дугуй хэлбэртэй нүхэлгээний машин;*<br>*- далд оёоны машин;*<br>*- гагнаасан холбоосны тусгай зориулалтын машин;*<br>*-үс, хөвөрдлөгөөний машин;*<br>*- ханцуй залгах зориулалтын машин;*<br>*-малгайн саравч залгах тусгай зориулалттай машин;*<br>*-сүлжмэл бүтээгдэхүүнийг сүлжих зориулалтын машин;*<br>*- өвлийн болон саравчтай малгайн цахилгаан хэв;*<br>*-гутлын толгой татлагын машин;*<br>*-зах нимгэлгээний машин;*<br>*-гутал, арьс, ширэн бүтээгдэхүүний эсгүүрийн машин ;*<br>*-гутлын өсгий татлагын машин;*<br>*-гутлын зуузай хэвшрүүлэх машин;*<br>*-гутлын улны цавуу идэвхжүүлэх, ул шахаж наах машин;*<br>*-гутлын ул нэвт оёх, хадах, үрэх машин;*<br>*-гутлын өнгөлгөөний машин;*<br>*- гутлын хэвлүүр (колодка);*<br>*- кноп хадагч маши;н*<br>*-үйлдвэрийн зориулалттай уурын индүүний иж бүрдэл;*<br>*- пресс индүү;*<br>*- хатгамлын зориулалттай 12-24-36 толгойтой машин гэх мэтээр хязгаархалгүй.*<br><br>Туслах тоног төхөөрөмжүүд (эмжээрийн аппарат, чимэг оёдол, цахилгаан шахагч ул, гуурс хадагч, нүх гаргагч цоолтуур, чийг дулааны боловсруулалт хийх үед шаардагдах колодка, туслах үлгэр, шаблом, шошго хадагч буу, утас таслагч-цэвэрлэгч) гэх мэт бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүд байна.<br><br>• Тендерт оролцогч нь тендер санал болгосон багцад хамаарах барааг нийлүүлэхэд ашиглах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлийн мэдээлэл, тэдгээрийг цаг хугацаанд нь бэлэн байлгах хэлбэр (өөрийн өмчлөл, эзэмшлийн,түрээслэх)-ээр гаргаж, үйлдвэрлэлийн ажлын байрны мэдээлэлийн хамт ирүүлнэ.<br><br>Оролцогчид тавигдах санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлт, шаардлага: ***“Шаардана”***<br><br>1.Сүүлийн 2 жил (2022, 2023)-ийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ: **Тендер ирүүлсэн багцын нийт үнийн дүнгийн 25 хувиас багагүй байна.**<br><br>2.Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн (эргэлтийн) хөрөнгийн хэмжээ: **Тендер ирүүлсэн багцын нийт үнийн дүнгийн 25 хувиас багагүй байна**. |

Гэрээний үүргийн биелэлтийг хангах мөнгөн хөрөнгийн хэмжээний нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:

- Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаарх харилцагч банкны мэдэгдэл;
- Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолтыг тус тус ирүүлнэ.

Хэрэв “Судлан үзэж, шаардлага хангасан тохиолдолд” гэсэн тодорхойлолт ирүүлвэл үнэлгээнд харгалзан үзэхгүй.

• Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд;

Оролцогчийн техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлага: ***“Шаардана”***

- Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дараах хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. Үүнд:

| № | ***Захиалагчийн техникийн тодорхойлолт***<br>*(Тухайн барааны үзүүлэлт тус бүрийг дор жагсааж бичих ба хэрвээ чанарын баталгаат хугацаа шаардах бол бичнэ үү.)* | ***Санал болгож буй техникийн тодорхойлолт***<br>*(захиалагчийн техникийн тодорхойлолтыг хуулахгүй байхыг анхаарна уу. Зөвхөн санал болгож буй барааны техникийн тодорхойлолтыг бичнэ үү.)* | ***Тайлбар***<br>*(дээрх үзүүлэлтийг нотлох баримт бичиг болон танилцуулгыг хавсаргана)* |
|---|---|---|---|
| 1 | | | |
| 2 | | | |

**ТШЗ 18.2** Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: ***“Шаардахгүй”***

**ТШЗ 19.1** Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: ***“Тийм”***

Тендерт оролцогч дотоодын аж ахуй эрхлэгч нь:

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана.

Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай.

Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана.

***-Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар “Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх” талаар Зээлийн***

| | |
|---|---|
| | ***мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр гаргуулан ирүүлнэ.***<br><br>Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно.<br><br>(“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)<br><br>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: ***Сүүлийн 2 жил (2022, 2023 он)***<br><br>-2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчийн сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг үнэлгээнд харгалзана. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-38, 39 дүгээр загвар, Цагдаагийн алба хаагчийн бүс, тэлээний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0503:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | “ Цагдаа “ ханцуйн бэлгэдэл тэмдгийг батлагдсан загварын өнгөөр хатгаж хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Ханцуйн бэлгэдэл тэмдэг / шонхортой, зангуугүй/-2000 ширхэг<br>Ханцуйн бэлгэдэл тэмдэг / соёмботой, зангуугүй/-2000 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт- соёмботой, шонхортой зангуугүй ханцуйн бэлгэдэл тус бүрээс 1 ширхгийг ирүүлнэ./ | “ Цагдаа” ханцуйн бэлгэдэл тэмдгийг хар хөх өнгөтэй нэхмэл даавуугаар суурь хийж дээд талд нь төрийн далбааны дүрсийг 1.5 см-ийн өндөртэй гаргаж, түүний дээр “MONGOLIA” гэсэн бичиглэлийг 0,8 см-ийн өндөртэйгөөр, доод талд нь “POLICE” гэсэн бичиглэлийг мөн 0,9 см-ийн өндөртэйгөөр цагаан саарал өнгийн торгомсог утсаар голлуулан нэхсэн байна.<br><br><br>Ханцуйн бэлгэдэл тэмдгийн голд “ЦАГААН ШОНХОР”-ын дүрсийг цэнхэр суурь дээр цагаан өнгийн торгомсог утсаар товойлгон хатгаж, түүний хошуу, гар, хөлийн сарвуут шар өнгийн торгон утсаар хатгаж, түүнийг тойрсон цагаан дэвсгэр хүрээний 2 хажуу талд нь “МОНГОЛЫН ЦАГДАА”гэсэн бичиглэлийг уйгаржин монгол бичгээр, “POLICE” гэсэн бичиглэлийг 0.5 см-ийн өндөртэйгөөр цагаан цэнхэр өнгийн утсаар хатгаж улаан хүрээгээр хүрээлсэн байна.<br><br>Ханцуйн бэлгэдэл тэмдгийн голд “Соёмбо”–ын дүрсийг цагаан саарал өнгийн торгомсог утсаар товойлгон хатгаж, түүний доод сууриндбадамлянхуа цэцгийг мөн цагаан саарал торгон утсаар хатгаж, түүний 2 хажуу талд нь “МОНГОЛЫН ЦАГДАА” гэсэн бичиглэлийг уйгаржин монгол бичгээр бичиж хатгасан байна.<br><br>Ханцуйн бэлгэдэл тэмдгийн гадна талд 3 мм-ийн өргөнтэй хар хөх хүрээ, түүнтэй зэрэгцүүлэн мөн хэмжээтэй цагаан саарал хүрээг гаргаж, 8,5 см х 11 см-ийн хэмжээтэйгээр доод үзүүр нь нарийссан хэлбэртэй хийж, ар талыг нааж хатуулсан байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнийг 20 ширхгээр багцалж, 500 ширхгээр цаасан хайрцагт савласан байна. |

## Хоёр. Дотооддоо үйлдвэрлэх боломжгүй, барааны техникийн тодорхойлолт

**Багцын дугаар-28**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Берет малгай**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт өдөр тутмын хувцастай хослуулж хавар, намрын улиралд өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 1-04 дүгээр загвар, Цагдаагийн алба малгайны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0493:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар хөх (Black lirs Pantone 19-3921 TPX Color hex #161d29) өнгөтэй 90 хувийн ноос, 10 хувийн акрилын холиотой, 580-600 г/м$^2$ жинтэй, бүрзийлт /7000 эргэлтэд/ 4 баллаас багагүй, элэгдэл тэсвэрлэлт 50000 эргэлтийн тооноос багагүй, норгосны дараах хэмжээний өөрчлөлт тууш, хөндлөн ±2,0 хувиас ихгүй материалаар хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна.<br>/Үндсэн материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 5000 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт- 60 размерын малгай ирүүлнэ/ | Хар хөх өнгийн нарийн ноосон цэмбээр малгайг дугуй хэлбэр гарган хэвлэж, доод ирмэгийг хар өнгөтэй савхиар эмжиж оёсон байна.<br><br>Берет малгайн баруун талыг голлуулан 7мм-ийн диаметртэй хар өнгөтэй 2 ширхэг гуурсыг хоорондоо 2,5 см, малгайн доод ирмэгээс дээш 2,5 см-ийн зайтайгаар байрлуулан хадсан байна.<br><br>Берет малгайн доод талын задгай ирмэгийг 1,0 см-ийн өргөнтэй савхиар эмжиж, эмжээрийн дотор талд малгайг чангалж өмсөх зориулалт бүхий бүчийг гүйлгэж, өмсгөл хэмжээг хавчуулж оёсон байна.<br><br>Берет малгайн бүчийг хар өнгөтэй, 0,7см-1,0 см-ийн өргөнтэй зориулалтын тасмаар хийх бөгөөд малгайн арын гол дахь хүрээний эмжээрийн төгсгөлөөр бүчний 2 талын задгай үзүүрийг 20 см-ийн урттайгаар гадагш ил гаргаж унжуулсан байна.<br><br>Берет малгайн үндсэн болон дотор Саналгүй. Тус төслийн санлыг дэмжиж байна.ын хөвөн даавуун материал нь хэвлэж өмсөхөд эвтэйхэн байхаар биелэг зөөлөн байхын зэрэгцээ эдэлгээний явцад өнгөө алдаж ганддаггүй, будаг гардаггүй байх шаардлагатай.<br><br><br><br>МУЗГ-ын 2017 оны 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-22 дугаар загварын малгайн тэмдгийн хамт нийлүүлнэ. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Берет малгайг нэг бүрчлэн ууталж 100 ширхгээр цаасан хайрцагт давхар савласан байна. |

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол



# 1 БЕРЕТ МАЛГАЙ

**ЗАГВАРЫН ДУГААР: 1-04**

**ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:**
Берет малгайг цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намар, зуны улиралд малгайн тэмдгийг хадаж, өдөр тутмын хувцастай өмсөж хэрэглэнэ.







**МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР**

Берет малгайг 100%-ийн ноосны холиотой хар хөх өнгийн эсгийг хэвлэж хийнэ.

**Багцын дугаар-29**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Албаны хүрэм**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт зун, хавар, намрын улиралд бүх төрлийн дүрэмт хувцастай хослуулан өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар зарлигаар батлагдсан 2-19, 2-20 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн өвлийн болон хээрийн хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0496:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуй, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Албаны хүрмийг хар хөх /Dark navy, Pantone 19-3921 TPX, Color hex #19a1e/ өнгөтэй, 100%-ийн полиэстерийн холиотой, 320-350 г/$м^2$ жинтэй, 1.32-1.37 мм зузаан, бүрзийлт /7000 эргэлтэд/ 4 баллаас багагүй, тасралтын даац тууш 48-53, хөндлөн 35-40 кг хүч, багагүй, элэгдэл тэсвэрлэлт 50000 эргэлтээс багагүй, агаар нэвтрүүлэлт 230-240 л/цаг-$см^2$ , 83-88 мм/сек, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4 баллаас багагүй материалаар хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн материалаар үйлдвэрлэх.<br><br>/Үндсэн материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Үндсэн материал нь хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй формальдегидийн хэмжээ 60 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 10377 ширхэг |
| 6 | Ачуулах хугацаа | 2024.03.25-аас 2024.09.30 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Албаны хүрмийг хар хөх өнгөтэй даавуугаар шулуун хэлбэртэй, босоо захтай, энгэр нь уулзсан цахилгаан товчлоостой, ар тал болон энгэрийн дээд талд хөндлөн оруулгатай, энгэрийн оруулгад орсон далд халаастай, ташаандаа хагалбар халаастай,мөрдэс тогтоогчтой, ердийн залгаа ханцуйтай, тохойн хэлбэрийг гаргасан оруулгатай, ханцуйн үзүүр, ташааны хагалбар онооны хэсэгт сойлттой, хормойн хэсгээр татуургатай.<br>Албаны хүрмийн арын дээд оруулга, ханцуйн хэсгийг торгон дотроор, энгэрийн дээд оруулгаас доош хормой хүртэл торон дотроор доторлож, зүүн талын энгэрийн дотор талд цахилгаан товчлоостой халаастай, энгэрийн товчлоос нь далд даруулгатай хийгдсэн.<br><br>Албаны хүрмийн зүүн, баруун талын ханцуйн “Цагдаа” бэлгэдэл тэмдгийг наах зөөлөн зангууг ханцуйн залгаанаас доош 3,5 см-зайтай, энгэрийн халаасны дээд талд энгэрийн бичиглэл, хувийн дугаар цусны бүлгийг наах зориулалттай 2,5 х 14,5 см-ийн хэмжээтэй зөөлөн зангууг голлуулан тус тус хадсан байх бөгөөд зөөлөн зангуу нь эдэлгээний шаардлагад нийцсэн.<br><br>Албаны хүрмийн арын дээд талд мөнгөлөг саарал өнгийн гэрэл ойлгогч туузаар “POLICE” бичиглэлийг 31 см-ийн урт, 7,5 см-ийн өндөртэйгөөр хийж, үсгийн гадна ирмэгүүдийг өнгө дагуу торгон утсаар хатгасан.<br>Албаны хүрмийн ташаа нь 2 толгойтой цахилгаанаар нэгтгэгдэж холбогдсон байх бөгөөд энэ алба хаагчид хамгаалах тусгай хэрэгслээ суран бүснээсээ авах, агаар нэвтрүүлэх зориулалттай болно.<br>Албаны хүрмийн нэгтгэсэн хэсгийн чимэг оёдол нь 0,2-0,8 см, зах, мөрдэс тогтоогч, ханцуй, хормойн сойлт, халаасны оруулгын ирмэг, энгэрийн товчлоосны оёдлууд нь 0,2 см -ийн хэмжээтэй.<br>Албаны хүрэм нь биед эвтэйхэн, хөнгөн, хөдөлгөөнд саад болохоорггүй, суулт тохироо, өмсгөл хэмжээ таарамж сайтай хийгдсэн байх шаардлагатай. |

| | | |
|---|---|---|
| | / Загварт 50,3 размерын хүрэм ирүүлнэ/ |  Хүрмийн цахилгаан товч нь хар хөх өнгөтэй даавуун суурьтай, сатуркан /нейлон/ шүдтэй, төмөр толгойтой, бээлийтэй үед тайлах зориулалтын уя бүхий татуургатай, #5 номерын хэмжээтэй, эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан -45 хэмд тэсвэртэй.<br><br>Албаны хүрэмд “Шонхор” бэлгэдэлтэй кнопон товчийг хадсан байна. Кнопон товч нь 18 мм-ийн диаметртэй дугуй хэлбэртэй, толгой суурь тэдгээрийн түгжигч гэсэн 4 иж бүрдлээр хийгдсэн.<br><br>Шонхортой кнопон товчны толгой нь 2 мм-ийн зузаантай, өнгөн талд нь “Шонхор шувуу”-ны дүрсийг 13 мм-ийн өндөр, 12 мм-ийн өргөнтэйгөөр голлуулан байрлуулж, түүний доод талд “POLICE” гэсэн бичиглэлийг ирмэгийг дагуулан товойлгож гаргасан зэрэг болно. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнд хэрэглээний заавар, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг зүүж, размераар нь төрөлжүүлэн нэг бүрчлэн ууталж цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж, хаягжуулсан байна. |

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол



## ГАДУУР ХУВЦАС

# 2 АЛБАНЫ ХҮРЭМ

**ЗАГВАРЫН ДУГААР:** **2-19-20**

**ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:**
Албаны хүрмийг цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар хавар, намар, зуны улиралд өдөр тутмын хувцастай албаны мөрдэс зүүж өмсөж хэрэглэнэ.











**МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР**

Албаны хүрмийг 100%-ийн полиэстер холиотой, дотор тал нь үслэг гадаргуутай хар хөх өнгийн даавуугаар хийнэ.

**Багцын дугаар-30**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Гэрэлтүүлэгчтэй хантааз (зуны)**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт өдөр тутам өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 367 дугаар тогтоолоор батлагдсан 2-27 дугаар загвар, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цацруулагчтай зуны хантаазыг мөнгөлөг саарал өнгөтэй, 100% полиэстерийн холиотой, 160-180 г/м$^2$ жинтэй, 0.6-0.7 мм зузаан, элэгдэл тэсвэрлэлт 35000 эргэлтээс багагүй, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 баллаас багагүй эдэлгээ даадаг, урт 3 мм, өргөн 2 мм хэмжээний нүхтэй торон материалаар,<br><br>Оруулга болон халаасыг хар өнгөтэй, 100% полиэстерийн холиотой, 320-340 г/м$^2$ жинтэй, 0.55 мм зузаан, ус нэвтрүүлдэггүй, 1000D, хог шороо татдаггүй, үрчийдэггүй, нэхмэл материалын гадаргуу дахь норголт 3 балл, будгийн тогтвор усанд, үрэлтэд 4-5 баллаас дээш материалаар хийх бөгөөд эдгээр нь хувцасны физик, механик шинж чанар, эдэлгээ, хэрэглээ, эрүүл ахуйн шаардлагад бүрэн нийцсэн байна.<br><br>мөнгөлөг цагаан /Silver, Pantone 14-5002 TPX, Color hex #bfc0c0/ өнгөтэй 35 хувийн хөвөн, 65 хувийн полиэстерийн холиотой, 300-330 г/м$^2$ жинтэй, 0.35-0.38 мм зузаан, бүрзийлт 4-5 баллаас багагүй, цацаргалтын коэффициент 260-270 CPL-ээс багагүй, цацаргалт үүсгэгч давхаргын зузаан 210-260 микрон, угаалга тэсвэрлэх чадвар /60$^0$С-т/ 25-30 удаа байх цацруулагч туузыг хадаж хийх бөгөөд эдгээр нь материалын физик, механик шинж чанар, эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна.<br><br>/Саарал тор, хар даавуу, цацруулагч туузан материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй усан экстрактын орчинд pH 4.8-7.5 балл байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 11400 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа |   Гэрэлтүүлэгчтэй зуны хантааз нь ар, энгэр гэсэн хоёр бүрдэл хэсэгтэй, цахилгаан товчилгоотой байх бөгөөд элэлтэд тэсвэртэй саарал өнгийн торон материалаар өнгийг, зориулалтын хар материалаар оруулга, халаасыг, зах, энгэр, ханцуйн ухаар, хормой, тогтоогч зангуу, халаас, халаасны таг зэргийг оруулгын материалын өнгөтэй ижил өнгийн хар өнгийн даавуун материалаар 1 см-ийн өргөнтэйгөөр зориулалтын машинаар цэвэр үзэмжтэй эмжиж оёно. |

Гэрэлтүүлэгчтэй зуны хантаазны арын хөндлөн чигт 2 эгнээ, мөрний оруулгын доод хэсэгт 1 эгнээ, энгэрийн хөндлөн чигт 2 эгнээ 5 см өргөнтэй цацруулагч туузыг өнгө дагуу утсаар дарж оёсон байна. Энгэрийн дээд хөндлөн цацруулагчийн дагуу хувийн дугаар, нэрийн бичиглэлийг наах зориулалттай 2,5 см х 14,5 см-ийн хэмжээтэй зангуу /эм/-г голлуулан хадсан байна.



Гэрэлтүүлэгчтэй зуны хантаазыг биеийн өмсгөл хэмжээ болон дүрэмт хувцасны эзлэхүүнтэй уялдуулан биедээ тохируулан өмсөх зориулалт бүхий уяа болон зангуутай товчлоосыг зурагт заасны дагуу энгэр хэсэгт зөөлөн зангуу /эм/-г 10 см-ийн өргөн, арын оруулгын үзүүрт 5 см-ийн өргөн хатуу зангуу /эр/-г эмжээрт оруулан оёсон байна. Уяаны үзүүрт зориулалтын хязгаарлагчтай байна. Зангуу нь нягт, бөх бат олон удаагийн угаалт, элээлтэд барилт сайтай байх шаардлагатай.

Гэрэлтүүлэгчтэй зуны хантаазны арын голд 27 см х 10,5 см-ийн оруулгын хар өнгийн нейлон материал дээр 23 см х 6,6 см хэмжээтэй “POLICE” бичиглэлийг мөнгөлөг цагаан /гэрэлтүүлэгч туузтай ижил/өнгийн гэрэл ойлгогчтой будгаар угаалт, элээлтийн явцад салж унахааргүй бөх, бат байхаар бичсэн байна.

Тус бичиглэл нь хатуу /эр/ зангуу тогтоогчтой байх бөгөөд эх биед зөөлөн ижил хэмжээтэй зангуу /эм/-г оёсон байна.




Гэрэлтүүлэгчтэй зуны хантаазны мөрний дээд хэсэгт зөөлөвч бүхий нэмэлт давхарлагтай оруулга хар өнгийн нейлон материалаар нэмэлт давхаргатай байна.





Хантаазны баруун талаан дээд хэсэгт хар өнгийн торон материалаар гар

| | | |
|---|---|---|
| | / Загварт 50,3 размерын хантааз ирүүлнэ/ | станцын халаас, зүүн талын дээд хэсэгт энгэрийн камер тогтоох 2,5 см бэлэн туузыг харалдаа доод хэсэгт резин тогтоогчийн хамт оёсон байна<br><br>Гэрэлтүүлэгчтэй зуны хантаазны доод хэсэгт бугуйн гав, шалгах төхөөрөмж, хийн бортого, гар чийдэн агуулах ил халаастай байх бөгөөд шалгах төхөөрөмж, хийн бортого, гар чийдэн агуулах халаасны доод хэсэгт борооны ус гаргах гуурсыг хадаж тогтоосон байна. Мөн хийн бортого, гар чийдэн агуулах халаасны дээд хэсэгт зангуу товчлоостой резин тогтоогч байна.<br><br>Хантаазны зүүн, баруун энгэрийн дотор талд тэмдэглэлийн дэвтэр агуулах зангуу товчилготой халаастай байна.<br>Хантаазны энгэрийн цахилгаан товч нь хар өнгөтэй даавуун суурьтай, сатуркан /нейлон/ шүдтэй, төмөр толгойтой байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан -45 хэмд тэсвэртэй #9 номерын хэмжээтэй байна.<br><br>Гэрэлтүүлэгчтэй хантаазны арын бүсэлхийн хэсгийн гэрэл ойлгогч туузын дээд, доод хэсэг, баруун талын энгэрийн бугуйн гав, гар чийдэн агуулах халаасны дээд хэсэгт зориулалтын 2,5 см өргөн бэлэн хар өнгийн туузыг оёсон байна |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнд хэрэглээний заавар, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг зүүж, размераар нь төрөлжүүлэн нэг бүрчлэн ууталж цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж, хаягжуулсан байна. |
| 9 | Загвар зураг |  |

**Багцын дугаар-31**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Гэрэлтүүлэгчтэй хантааз (өвлийн)**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт хүйтний улиралд өдөр тутам өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 367 дугаар тогтоолоор батлагдсан 2-28 дугаар загвар, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цацруулагчтай өвлийн хантаазыг мөнгөлөг саарал өнгөтэй, 50% хөвөн, 50% полиэстерийн холиотой, 240-250 г/м$^2$ жинтэй, 0.35-0.40 мм зузаан, элэгдэл тэсвэрлэлт 35000 эргэлтээс багагүй, нэхээсний нягт түуш 380-390, хөндөлөн 210-220, тасралтын даац түуш 165-170, хөндлөн 65-70 кг хүч, суналт түуш 30-35, хөндлөн 5-10 хувь, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 баллаас багагүй хөвөн даавуун материалаар,<br>Оруулга болон халаасыг хар өнгөтэй, 100% полиэстерийн холиотой, 320-340 г/м$^2$ жинтэй, 0.55 мм зузаан, ус нэвтрүүлдэггүй, 1000D, хог шороо татдаггүй, үрчийдэггүй, нэхмэл материалын гадаргуу дахь норголт 3 балл, будгийн тогтвор усанд, үрэлтэд 4-5 баллаас дээш материалаар хийх бөгөөд эдгээр нь хувцасны физик, механик шинж чанар, эдэлгээ, хэрэглээ, эрүүл ахуйн шаардлагад бүрэн нийцсэн байна.<br>Мөнгөлөг цагаан /Silver, Pantone 14-5002 TPX, Color hex #bfc0c0/ өнгөтэй 35 хувийн хөвөн, 65 хувийн полиэстерийн холиотой, 300-330 г/м$^2$ жинтэй, 0.35-0.38 мм зузаан, бүрзийлт 4-5 баллаас багагүй, цацаргалтын коэффициент 260-270 CPL-ээс багагүй, цацаргалт үүсгэгч давхаргын зузаан 210-260 микрон, угаалга тэсвэрлэх чадвар /60$^0$С-т/ 25-30 удаа байх цацруулагч туузыг хадаж хийх бөгөөд эдгээр нь материалын физик, механик шинж чанар, эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна.<br><br>/Саарал болон хар даавуу, цацруулагч туузан материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй усан экстрактын орчинд pH 4.8-7.5 балл байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 11400 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Гэрэлтүүлэгчтэй өвлийн хантааз нь ар, энгэр гэсэн хоёр бүрдэл хэсэгтэй, цахилгаан товчилготой байх бөгөөд элээлтэд тэсвэртэй, гялгар гадаргуутай хөвөн даавуун материалаар өнгийг, зориулалтын хар материалаар оруулга, халаасыг, зах, энгэр, ханцуйн ухаар, хормой, тогтоогч зангуу, халаас, халаасны таг зэргийг оруулгын материалын өнгөтэй ижил өнгийн хар өнгийн даавуун материалаар 1 см-ийн өргөнтэйгөөр зориулалтын машинаар цэвэр үзэмжтэй эмжиж оёно.<br><br>Гэрэлтүүлэгчтэй өвлийн хантаазны арын хөндлөн чигт 2 эгнээ, энгэрийн хөндлөн чигт 2 эгнээ 5 см өргөнтэй цацруулагч туузыг өнгө дагуу утсаар дарж оёсон байна. Энгэрийн дээд хөндлөн цацруулагчийн дагуу хувийн дугаар, нэрийн бичиглэлийг наах зориулалттай 2,5 см х 14,5 см-ийн хэмжээтэй зангуу /эм/-г голлуулан хадсан байна.<br><br>Гэрэлтүүлэгчтэй өвлийн хантаазыг биеийн өмсгөл хэмжээ болон дүрэмт хувцасны эзлэхүүнтэй уялдуулан биедээ тохируулан өмсөх зориулалт бүхий зангуутай товчлоосыг энгэр хэсэгт зөөлөн зангуу /эм/-г 10 см-ийн өргөн, арын оруулгын үзүүрт 5 см-ийн өргөн хатуу зангуу /эр/-г эмжээрт оруулан оёсон байна. Зангуу нь нягт, бөх бат олон удаагийн угаалт, элээлтэд барилт сайтай байх шаардлагатай. |

<table>
<tr>
<td></td>
<td>Загварт 50,3 размерын хантааз ирүүлнэ/</td>
<td>



Гэрэлтүүлэгчтэй өвлийн хантаазны арын голд 27 см x 10,5 см-ийн оруулгын хар өнгийн нейлон материал дээр 23 см x 6,6 см хэмжээтэй “POLICE” бичиглэлийг мөнгөлөг цагаан /гэрэлтүүлэгч туузтай ижил/өнгийн гэрэл ойлгогчтой будгаар угаалт, элээлтийн явцад салж унахааргүй бөх, бат байхаар бичсэн байна.

Тус бичиглэл нь хатуу /эр/ зангуу тогтоогчтой байх бөгөөд эх биед зөөлөн ижил хэмжээтэй зангуу /эм/-г оёсон байна.

Гэрэлтүүлэгчтэй өвлийн хантаазны мөр хэсгийн дотор зөөлөвч бүхий нэмэлт давхаргатай байна.






Хантаазны баруун талаан дээд хэсэгт хар өнгийн торон материалаар гар станцын халаас, зүүн талын дээд хэсэгт энгэрийн камер тогтоох 2,5 см бэлэн туузыг харалдаа доод хэсэгт резин тогтоогчийн хамт оёсон байна




Гэрэлтүүлэгчтэй өвлийн хантаазны энгэрийн доод хэсэгт бугуйн гав, шалгах төхөөрөмж, гар чийдэн, хийн бортого, гар утас агуулах ил халаастай байх бөгөөд шалгах төхөөрөмж, гар утас, хийн бортого, гар чийдэн агуулах халаасны доод хэсэгт гуурсыг хадаж тогтоосон байна.

Хантаазны зүүн, баруун энгэрийн дотор талд тэмдэглэлийн дэвтэр агуулах зангуу товчилготой халаастай байна.

Хантаазны энгэрийн цахилгаан товч нь хар өнгөтэй даавуун суурьтай, сатуркан /нейлон/ шүдтэй, төмөр толгойтой байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан -45 хэмд тэсвэртэй #9 номерын хэмжээтэй байна.
</td>
</tr>
<tr>
<td>8</td>
<td>Баглаа боодол, барааны нэр, шошго</td>
<td>Бэлэн бүтээгдэхүүнд хэрэглээний заавар, размер, үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг зүүж, размераар нь төрөлжүүлэн нэг бүрчлэн уутлаж цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж, хаягжуулсан байна.</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| 9 | Загвар зураг |  |

**Багцын дугаар-32**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Хүзүүвч**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт өдөр тутмын хувцастай өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 2-30 дугаар загвар, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар өнгөтэй сүлжмэл, 100%-ийн полиэстерийн холиотой, суналттай, будгийн тогтвор хуурай, нойтон үрэлтэд, угаалгад, хөлсөнд, хими цэвэрлэгээнд 4-5 баллаас багагүй, үслэг гадаргуутай, 1м$^{2}$- ын жин нь 200-240 г/м$^{2}$, бүрзийдэггүй, үрчийдэггүй нэмэлт боловсруулалтай материалаар хийгдсэн байна.<br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг хамт ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүй байдал | Үндсэн материал нь хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 8400 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>Загварт 1 ширхэг хүзүүвчийг ирүүлнэ. | <br>Хүзүүвчийг 100 хувийн полиэстер, сунալт сайтай үсэрхэг /Fleece/ материалаар загвар зургийн дагуу хийсэн байна.<br>Хүзүүвчний дээд, доод ирмэгийг 2 см хэмжээтэйгээр дотогш нугалж зориулалтын сүлжмэлийн машинаар хос оёдол гаргаж оёх бөгөөд дээд нугалаасны дотор талаар суналттай уяг гүйлгэж, хоорондоо 2 см зайтай тусгай зориулалтын машинаар дугуй хэлбэртэй питель гаргаж түүгээр битүү гогцоо үүсгэн үзүүрт нь тойргийн хэмжээг багасгаж барих хязгаарлагч тогтоосон байна.<br>Хүзүүвчний аран гол хэсэгт 4см x 1см хэмжээтэй өнгө дагуу хар материал дээр “POLICE” бичиглэлийг дээрээс доош нь цагаан өнгөөр тэмдэглэсэн байх бөгөөд оёдолд оруулж оёсон байна.<br>Хүзүүвч нь хүний биетэй шууд харилцах учир эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, элээлтэд тэсвэртэй, дулаан хадгалах чадвар өндөртэй байх шаардлагатай. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнд размерын болон үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг хадаж, нэг бүрчлэн ууталж цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж хаягжуулсан байна. |

**Багцын дугаар-33**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Дан өмд**

| № | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт хавар, намар, зуны улиралд урт болон богино ханцуйтай өдөр тутмын цамц, поло цамц, захгүй цамц, ноосон цамц, захгүй цамц, тэмээний ноосон хантааз, агсамж зэрэг хувцастай өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 3-19, 3-20 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн өвлийн болон хээрийн хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0496:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуй, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Дан өмдийг хар хөх /Black Iris, Pantone 19-3912 TPX, Color hex #161b2b/ өнгөтэй, 60%-ийн хөвөн, 40%-ийн полиэстерийн холиотой, 220-240 г/м$^2$ жинтэй, 0.35-0.40 мм зузаан, 3х2 ташуу нэхээстэй, бүрзийлт /7000 эргэлтэд/ 4 баллаас багагүй, нэхээсний нягт тууш 450-460, хөндлөн 225-235, тасралтын даац тууш 60-70, хөндлөн 48-58 кг хүч, багагүй, элэгдэл тэсвэрлэлт 50000 эргэлтээс багагүй, агаар нэвтрүүлэлт 160-180 л/цаг-см$^2$ , 60-70 мм/сек, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4 баллаас багагүй материалаар хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн материалаар үйлдвэрлэх.<br><br>/Үндсэн материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Үндсэн материал нь хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй формальдегидийн хэмжээ 60 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 10243 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/ Загварт 50,3 размерын өмд ирүүлнэ/ | Дан өмд нь ташааны оёдолд орсон ташуу халаастай, баруун талын ташааны халаасны төлөөсний дээд талд “POLICE” бичиглэлтэй, баруун талын дээд хэсэгт цагны халаастай, баруун талын эхний түдгүүлд гархитай, ар тал нь 2 ширхэг танаастай, 2 ширхэг 1,5 см өргөн 1 хажлагатай хагалбар халаастай халаас тус бүр 1 ширхэг эвэр товчоор товчлогдох ба халаасыг голлуулан хадаж товчны нүхийг тусгай зориулалтын машинаар цэвэр үзэмжтэй гаргасан байна.<br><br>Дан өмд нь 6 см урт, 2 см-ийн өргөнтэй 6ш түдгүүлтэй, байх бөгөөд өмдний захнаас 1см-т суулгаж хадах ба баруун талын эхний түдгүүлд төмөр гархитай байна.<br><br>Дан өмдний халаа нь цахилгаан товчлоостой, захандаа эвэр товч болон давхар өмдний зориулалтын кнопон товчтой байна. Кнопон төмөр товчны толгой 20 мм-ийн диаметртэй дугуй хэлбэртэй, толгой суурь тэдгээрийн түгжигч гэсэн 4 иж бүрдлээр хийгдсэн байна.<br><br>Кнопон товч нь цулгуй өнгөтэй толгой нь 2 мм-ийн зузаантай байна.<br><br>Кнопон товчны толгойн дотор талд 5 мм-ийн өндөртэй, 5 мм-ийн диаметртэй шонтой төмрийг хавсарч, толгойн гадна ирмэгийг 1.5 мм-ээр дотогш давуулан дарж бэлтгэсэн байх ба толгойн дотор талын шонд 1мм-ийн голтой резинэн жийргэвчийг суулгасан байна.<br><br>Дан өмдний хажуугийн халаасны ирмэг, түдгүүл, халаасны таг 0.2 см-ийн, халаа нь 3.5 см-ийн, өмдний шуумаг 2,5 см-ийн чимэг оёдолтой, халаа, түдгүүл, халаасны ирмэгийг тусгай зориулалтын машинаар бөхөлж, захны үзүүрийн товчны нүхний үзүүрийг тусгай зориулалтын машинаар дугуй хэлбэртэй гаргаж, халаасны уутыг 0,5 см-аар эмжиж оёсон байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнд размерын болон үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг хадаж, нэг бүрчлэн ууталж цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж хаягжуулсан байна. |

| | | |
|---|---|---|
| 9 | Бүтээгдэхүүний зураг |  |

**Багцын дугаар-34**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Тоногтой бүс**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Тоногтой бүсийг цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нар өвлийн болон албаны хүрэм, өдөр тутмын хүрэм өмссөн үед хувцасны гадуур бүсэлхийн хэсгээр, савхин хүрэм, ноосон цамц,урт болон богино ханцуйтай хар хөх цамц, поло цамц, захгүй цамц өмссөн үед өмдний захны хэсгээр давхарлан бүсэлж хэрэглэнэ. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 367 дугаар тогтоолоор батлагдсан 5-01, 5-4, 5-7 дугаар загвар, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Тоногтой бүс нь удаан эдэлгээтэй хар өнгөтэй 100 хувийн нейлон, бат бөх PP доторлогооны материалаар хийгдэх бөгөөд гав, бороохой, бууг бүсэнд зүүхэд хэлбэрээ алдаж нугарахгүй, бүсэнд ирэх ачааллыг жигд хуваарилж байхаар хатуулга сайтай, эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна. /Үндсэн материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт 5800 иж бүрдэл |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Тоногтой бүсийг хар өнгийн нейлон материалаар 5 см өргөн, 0,6 см зузаантай, 95-145 см урттайгаар, полимер материалтай -45 хэмд тэсвэртэй, санамсаргүйгээр сулрах, бүсэн дэх нэг бүрийн тусгай хэрэгслийг эвдэж гэмтэхээс хамгаалсан 3 цэгээс даралт өгч тайлагдах аралтай байна.<br>Загвар зураг:<br><br><br>Тоногтой бүс нь дотуур бүс, гав, бороохойн гэр гэсэн нэмэлттэй байна. Дотуур бүс нь зангуу товчилготой, тэлээ болж хэрэглэгдэх зориулалттай хар өнгийн нейлон материалаар 3,7 см өргөн, 90-140 см урттай байна. Дотор бүсийг түдүүлд хийж тоногтой гадар бүстэй зангуугаар хөдөлгөөнгүй болгож барах зориулалтай хатуу зангуу /эр/-г салж хөндийрөлт үүсэхээргүй нэгтгэсэн, хатуулга сайтай байх шаардлагатай.<br>Загвар зураг:<br> |

| | | |
|---|---|---|
| | /Загварт- Тоноглой суран бүсний иж бүрдэл ирүүлнэ./ | ***Бороохойн гэр:*** Хар өнгийн 100 хувийн нейлон материалаар, 4 см диаметртэй резин бороохойг авч явах үед тогтоогч түдүүлээр бүсэнд сүвлэж зүүнэ.<br>***Бугуйн гавны гэр:*** Хар Хар өнгийн 100 хувийн нейлон материалаар, бугуйн гав авч явах үед тогтоогч түдүүлээр бүсэнд сүвлэж зүүнэ.<br>Тоноглой бүс, дотуур бүс, тоног нь эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байх шаардлагатай. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Тоноглой бүс болон тоноглолын гэрийг нэг бүрчлэн иж бүрдүүлэн ууталж, размераар нь төрөлжүүлэн, размерын болон үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг хадаж, нэг бүрчлэн ууталж цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж хаягжуулсан байна. |
| 9 | Загвар зураг | <br><br> |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Цамцны мөрдэс**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт ажил үүргээ гүйцэтгэх үед өдөр тутмын дүрэмт хувцсанд зүүх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-16,17,18,19,20 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн мөрдэсний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0502:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Албаны мөрдэсийг хар хөх (Black Iris, Pantone 19-3921 TPX Color hex #1f2939) өнгөтэй, хуяган хээн дэвсгэртэй материал дээр хүрээний хээ болон цолны тэмдгийг мөнгөлөг саарал өнгийн өндөр молекулт нэгдлээр хэвлэж шахаж хийсэн байх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Хурандаа цолны мөрдэс- 380 хос<br>Дэд хурандаа мөрдэс- 730 хос<br>Хошууч мөрдэс- 1650 хос<br>Ахмад мөрдэс- 2300 хос<br>Ахлах дэслэгч мөрдэс- 1950 хос<br>Дэслэгч мөрдэс 3400 хос<br>Ахлах ахлагч мөрдэс- 1900 хос<br>Ахлагч мөрдэс- 1640 хос<br>Дэд ахлагч мөрдэс- 6000 хос<br>Нийт- 20000 хос |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Албаны мөрдэсийг хар хөх өнгөтэй хуяган хээн дэвсгэртэй торгон туузан дээр цолны тэмдгийг хувцас өмсөх журамлан заасан хэмжээгээр байрлуулж мөнгөлөг саарал өнгөтэй резинээр өндөр молекулт нэгдлээр товойлгон шахаж, дүрэмт хувцасны мөрдэс тогтоогчид углаж зүүх зориулалттайгаар хийсэн байна.<br><br>Ахлах офицерын албаны мөрдэсний суурины өргөн 55 мм, дээд талын хошууны өргөн- 45 мм,хошууны өндөр 2.5 мм, урт 110 мм хэмжээтэйгээр хийж, дээд талын ирмэгийн өлзий хээг хүрээний хээтэй үргэлжилсэн байхаар товойлгон шахаж хэвлэж хийсэн байна.<br> |

| | | |
|---|---|---|
| | /Загварт мөрдэс тус бүрээс 1 хосыг ирүүлнэ/ | Дунд офицерын албаны мөрдэсний суурины өргөн 55 мм, дээд талын хошууны өргөн 45 мм, урт нь 110 мм хэмжээтэйгээр хийж, дээд талын ирмэгийн өлзий хээг хүрээний хээтэй үргэлжилсэн байхаар товойлгон шахаж хэвлэж хийсэн байна.<br><br><br>Ахлагчийн албаны мөрдэсний суурины өргөн 55 мм, дээд талын хошууны өргөн 45 мм, урт нь 110 мм хэмжээтэйгээр хийж, дээд талын ирмэгийн өлзий хээг хүрээний хээтэй үргэлжилсэн байхаар товойлгон шахаж хэвлэж хийсэн байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнийг хослуулан, үйлдвэрлэгчийн шошгыг хадаж, нэг бүрчлэн ууталж, 20 хосоор багцалж, 500 хосоор цаасан хайрцагт савлаж, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-36**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Цолны тэмдэг**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагчдын ёслол, албаны хувцасны мөрдөс дээр хадах зориулалттай туслах материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-01, 6-07, 6-13 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн мөрдэсний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0502:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цолны тэмдгийг төмрөөр төмрийн уусмалд бүрж, мөнгөлөг цагаан өнгөтэй болгож хийх бөгөөд ахлах цолны тэмдэг /том таван хошуу/ 0,20-0,21 грамм, дунд цолны тэмдэг /жижиг таван хошуу/ 0,066-0,067, ахлагч цолны тэмдэг /гурвалжин/ 0,143-0,145 грамм, /тэгш өнцөгт/ 0,108-0,110 грамм жинтэй, эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Ахлах цолны тэмдэг- 8200 ширхэг<br>Дунд цолны тэмдэг- 42240 ширхэг<br>Ахлагч цолны тэмдэг- 29460 ширхэг<br>Сургагч ахлагч цолны ялгах тэмдэг- 100 ширхэг<br>Нийт- 80,000 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт тэмдэг тус бүрээс 1 ширхгийг ирүүлнэ/ | Цагдаагийн мөрдэсний цолны тэмдэг нь мөнгөлөг өнгөтэй, ус чийг болон эдэлгээний явцад өнгө нь хувирахгүй, хугарахгүй бөх бат чанартай металлаар хийгдсэн байна.<br><br>Цагдаагийн ахлах цолны тэмдгийг 22 мм-ийн диаметртэй, 5 мм-ийн зузаантай таван хошуу хэлбэртэй хийх бөгөөд үзүүрээс төврүүгээ 1мм-ийн өргөнтэй эрчилсэн хээтэй байна.<br><br>Цагдаагийн дунд цолны тэмдгийг 15 мм-ийн диаметртэй , 3 мм-ийн зузаантай таван хошуу хэлбэртэй хийх бөгөөд үзүүрээс төврүүгээ 1мм-ийн өргөнтэй эрчилсэн хээтэй байна.<br><br>Цагдаагийн ахлагч нарын цолны тэмдгийг 17 мм-ийн өргөн, 22 мм-ийн урт, 4 мм-ийн зузаантай гурвалжин хэлбэртэй 1 мм-ийн өргөнтэй эрчилсэн хээтэй байна.<br><br>Цагдаагийн сургагч ахлагч, тэргүүн ахлагч цолны ялгах тэмдэг нь 22 мм-урт, 6 мм-ийн өргөн, 4 мм-ийн зузаантай тэгш өнцөгт хэлбэртэй 1 мм-ийн өргөнтэй эрчилсэн хээтэй байна.<br><br>Цолны тэмдгийн арын голд 1 см урттай резьватай тогтоогч шон байрлах бөгөөд дугуй хэлбэртэй боолтоор эргэдэж бэхлэгдэнэ.<br><br>Тогтоогч шонг гантай төмрөөр тэмдгийн голд сайтар гагнаж тогтоосон байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Цолны тэмдгийг ангилан 200 ширхгээр ууталж, 10000 ширхгээр цаасан хайрцагт савлан, давхар ярликжуулсан байна. |

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол



# 6 ЦОЛНЫ ТЭМДЭГ

**ЗАГВАРЫН ДУГААР: 6-01, 6-07, 6-13**

**ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:**
Цолны тэмдгийг ёслол, албаны мөрдэсэнд хадаж хэрэглэнэ.





**МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР**

Цолны тэмдгийг мөнгөлөг саарал металлаар хэвлэж хийнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Ёслолын малгайн тэмдэг**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт ёслол жагсаалын үед ёслолын малгайн дээр зүүх зориулалттайгаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-21 дүгээр загвар, Цагдаагийн алба хаагчийн ялгах тэмдэгний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0503:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хатуу металл төмрийг төмрийн уусмалд бүрж, мөнгөлөг цагаан өнгөтэй болгон, Монгол Улсын сүлдийг батлагдсан загварын өнгөөр нь голлуулан өөрөөс нь үргэлж байдлаар хэвлэж, цутгаж хийсэн байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 2000 хос |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загвар 1 ширхэг ёслолын малгайн тэмдэг ирүүлнэ./ | Мөнгөлөг цагаан өнгөтэй малгайн тэмдгийн нийт урт 20 см, голын өндөр 4,9 см, түүний хажуу талын цэцгийн өндөр 4,5 см хавтгай хэлбэртэй байна.<br><br>Ёслолын малгайн тэмдгийн суурийн доод хэсгээрээ 3,3 см бадамлянхуа цэцгийн дэлбээн дээр суурилсан тойргийг хүрээлсэн хэвтээ байрласан үргэлжилсэн тариан түрүүтэй, түүнийг ороосон өлзий хээтэй хийгдсэн байна.<br><br><br>Ёслолын малгайн тэмдгийн гол нь 3,6 см-ийн диаметртэй 0.7 см-ийн зузаантай тойргийг гадагш налуулан зураасан эрчлээсээр хүрээлэн товойлгон гаргасан дотор талын 2.5 см-ийн диаметртэй цагаан паалан дэвсгэртэй тойрог дотор “Төрийн сүлд ”-ийг 1,9:2 см-ийн хэмжээтэйгээр батлагдсан загварын өнгөөр нь голлуулан өөрөөс нь үргэлж байдлаар хэвлэж, цутгаж хийсэн байна.<br><br>Ёслолын малгайн тэмдгийн арын голд 1.5 см урттай резватай тогтоогч шон дугуй хэлбэртэй боолтоор бэхлэгдэхээр, хоёр талд нь ижил зайнд тогтоогчийг мөн гагнаж тогтоосон байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнийг 1 ширхгээр нь ууталж, 1000 ширхгээр цаасан хайрцагт савлан, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-37**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Өдөр тутмын малгайн тэмдэг**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт өдөр тутмын хэрэгцээнд нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-22 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн ялгах тэмдэгний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0503:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хатуу металл төмрийг төмрийн уусмалд бүрж, мөнгөлөг цагаан өнгөтэй болгон, Монгол Улсын сүлдийг голд нь байрлуулан хийсэн байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 3000 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт 1 ширхэг малгайн тэмдэг ирүүлнэ./ | Малгайн тэмдэг нь бадамлянхуа цэцгийн дэлбээн дээр суурилагдсан, 2 талаараа 2 эгнээ давхарлагдсан навчаар хагас дугуй хэлбэртэй хүрээлэгдэж, хүрээний дотор талд 0.7 мм-ийн зузаантай, зураасан эрчлээстэй, 3.5 см-ийн диаметртэй тойрог байна.<br>Тэмдэгний суурь бадамлянхуа цэцгийн өндөр нь 1.0 см, доод хэсгээрээ 3.0 см, дээд хэсгээрээ 2.0 см урттай байна.<br><br>Малгайн тэмдгийн доторх сүлд байрлах тойрог нь 2.6 см, цагаан өнгийн дэвсгэртэй байх бөгөөд “Төрийн сүлд”-ийг 2,1:2 см-ийн хэмжээтэйгээр батлагдсан загварын өнгөөр нь өөрөөс нь үргэлж байдлаар хэвлэж, цутгаж хийсэн байна.<br><br>Малгайн тэмдгийн өргөн нь 6.0 см, өндөр нь 4.7 см байна.<br><br>Ёслолын малгайн тэмдгийн арын голд 1.5 см урттай резватай тогтоогч шон дугуй хэлбэртэй боолтоор бэхлэгдэхээр шонг сайтар гагнаж байрлуулсан байна.<br><br>Малгайн тэмдгийн 2 талын ирмэг нь дотор тал руу бага зэрэг дугуйрсан хэлбэртэй байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Малгайн тэмдгийг нэг бүрчлэн уутлаж, 1000 ширхэгээр нь цаасан хайрцганд савлаж, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-37**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Захны таних тэмдэг**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт албаны кителийн захандхадах зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-28 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн ялгах тэмдэгний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0503:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Захны таних тэмдгийг төмрөөр төмрийн уусмалд бүрж, мөнгөлөг цагаан өнгөтэй болгож хийх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 6000 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт 1 ширхэг тэмдэг ирүүлнэ/ | Захны таних тэмдгийг мөнгөлөг цагаан өнгөтэй төмрөөр 25 мм-ийн диаметртэй, дугуй хэлбэртэй хийх бөгөөд суурин хэсэгт бадамлянхуа цэцгийг 13 мм урт, 0.4 мм өндөртэйгөөр суурилуулж, 2 талын захын ирмэгийг дагуулан хоёр эгнээ тариан түрүүгээр хүрээлж, тэдгээрийг тойргийн дээд талд зураасан хээтэй хүрээгээр битүүлэн холбосон байна.<br><br>Захны таних тэмдгийн голын тойргийг цоолборлож, түүний дотор талд “Соёмбо “ тэмдгийг бадамлянхуа цэцгийн дотор талын суурин дээр голлуулан гадна тал руу товойлгон гаргаж хийсэн байна.<br><br>Захны таних тэмдгийн арын голд 0.8 см урттай резьбатай тогтоогч шон байрлах бөгөөд дугуй хэлбэртэй боолтоор эргэдэж бэхлэгдэнэ.<br><br>Тогтоогч шонг гантай төмрөөр тэмдгийн голд сайтар гагнаж тогтоосон байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Захны таних тэмдгийг нэг бүрчлэн ууталж, 1000 ширхгээр савлан, 10000 ширхгээр цаасан хайрцагт хийж, давхар ярликжуулсан байна. |

Монгол Улсын Засгийн газрын
2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
155 дугаар тогтоол

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ

**МӨРДЭС, ЯЛГАХ ТЭМДЭГ**

# 6 ЗАХНЫ ТАНИХ ТЭМДЭГ

**ЗАГВАРЫН ДУГААР: 6-28**

**ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:**
Таних тэмдгийг цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нар албаны кителийн захны буланд хадаж хэрэглэнэ.









**МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР**

Таних тэмдгийг мөнгөлөг саарал металлаар хэвлэж хийнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Зангианы хавчаар**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт өдөр тутам болон албаны хувцастай зангианд зүүж хэрэглэх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-27 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн бүсний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0501:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Зангианы хавчаарыг төмрөөр төмрийн уусмалд бүрж, мөнгөлөг цагаан, алтлаг шар өнгөтэй болгож хийх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Эрэгтэй загвараар 4500 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт 1 ширхэг зангианы хавчаар ирүүлнэ./ | “Цагдаа” бэлгэдэлтэй зангианы хавчаарыг мөнгөлөг цагаан өнгөтэй 6 см өргөн, 63 см урттайгаар бэлтгэсэн байна. Харагдах хэсгийн өргөнийг 0,2 см хэмжээтэйгээр тэнцүү хуваасан хэмжээтэй байна.<br><br>Зангианы хавчаарын үзүүрээс 0,7 см зайд цагдаагийн бэлгэдлийг батлагдсан өнгө загвар, стандартын дагуу 1,7 см хэмжээтэйгээр бэлтгэж өргөнийг голлуулан тогтоосон байна.<br><br>Зангианы хавчаар нь хэрэглээнд тэсвэртэй байх шаардлагатай.<br><br> |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Зангианы хавчаарыг нэг бүрчлэн ууталж, цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж, хаягжуулсан байна. |

**Багцын дугаар-38**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Ёслолын бээлий**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт ёслолын хувцсан дээр өмсөх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 2-31 дүгээр загвар, Цагдаагийн алба хаагчийн бүсний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0494:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цагаан /Bright white, Pantone 11-0601 TPX, Color hex #f1f2f1/ өнгөтэй, 100%-ийн хөвөн даавуун холиотой, 135-140 г/м$^2$ жинтэй, 0.55-0.60 мм зузаан, хирами сүлжээтэй хийх бөгөөд эдэлгээний шаардлагад бүрэн нийцсэн байна.<br><br>/Үндсэн материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлсон итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 2560 хос |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт 1 хос бээлий ирүүлнэ./ | Цагдаагийн алба хаагчдын ёслолын бээлийг цагаан өнгийн сунамтгай сүлжмэл материалаар 5 хуруутай, алганы гадна талд гоёлын оёдлыг 3 эгнээ зэрэгцүүлэн товойлгон гаргаж, дотор талын алганы шуун хэсэгт резинэн татуургыг татагдсан үед 3-4 см байхаар зиг-заг оёдлоор оёж, хуруунуудын салаа болон нэгтгэсэн оёдлуудыг зориулалтын сунамтгай цагаан утсаар оёсон байна.<br><br> |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнд размерын болон үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг хадаж, уутлаж, размераар нь төрөлжүүлэн 500 хосоор цаасан хайрцаганд савлан, давхар ярлыкжуулан байна. |

**Багцын дугаар-39**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Ёслолын саан унжлага**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт ёслол жагсаалын үед ёслол албаны хувцсан дээр кителийн баруун энгэрт зүүж хэрэглэх зориулалтаар нормоор олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 6-40 дүгээр загвар, техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Мөнгөлөг цагаан өнгөтэй 50 хувиас дээш төмөрийн орцтой саан утсаар сүлжиж хийсэн байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 8850 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загвар 1 ширхэг ёслолын саан унжлага ирүүлнэ./ | Мөнгөлөг цагаан өнгийн 7 мм-ийн голчтой төмөр саан утсан материалтай, унжлагатай, сойлттой, унжлага тус бүрийн үзүүрийн хэсэгт сумтай хийгдсэн байна.<br><br>Цагдаа саан унжлагын арын сүлжээтэй унжлага нь 70 см урттай, энгэрийн унжлага нь 46 см урттай, арын сойлтын урт 60 см, энгэрийн сойлтын урт 39 см байх бөгөөд ар энгэрийн унжлага, сойлтыг тус тусад нь бэлтгэж, үзүүрүүдийг нэгтгэн 4.5 см урттай, 2.5 см-ийн өргөнтэй саарал өнгийн даавуунд хавчуулан оёж, голд нь мөрдэс тогтоогчийн доор байрлах эвэр товчинд зүүх товчны нүхийг шулуун хэлбэртэй гаргасан байна.<br><br>Цагдаа саан унжлагын арын унжлагын үзүүрт 10 см-ийн урттай, энгэрийн унжлагын үзүүрт 9 см-ийн урттай төмөр саан утсаар сул үзүүр гаргаж, түүний үзүүрийг төмөр суманд сүвлэж, дээд талыг нь резватай боолтоор эргэдэж боосон байна.<br><br>Мөн урд талын сойлтын битүү үзүүрт энгэрийн товчинд товчлох гогцоог гаргаж, ар, энгэрийн сүлжээстэй унжлагын урд үзүүр, урд талын сойлтын үзүүрт битүү сүлжсэн түдүүлийг гүйлгэсэн байна.<br><br>Цагдаа саан унжлагын сум нь цагаан өнгийн никель төмөр материалтай,шилбэ болон толгой гэсэн 2 хэсэгтэй, шилбэний урт нь 9 см, үзүүр рүүгээ нарийссан конус хэлбэртэй, сумны шилбэ нь хоорондоо 2 см зайтай үзүүрээс дээш 1-3 хүртэл өссөн товойлгон гаргасан зураасан хүрээтэй, дээд ирмэг нь үргэлжилсэн түмэн наст хээн хүрээтэй, 1 см урттай гол нь хөндий резватай, түүнд унжлагын үзүүрийг сүвлэж тогтоох зориулалттай байна.<br><br>Саан унжлагын сумны толгой нь 1.5 см урттай, 0.9 см голчтой, доод талын 1 см-ийн өндөртэй шилбэнд бадамлянхуа цэцгийн суурин дээр “Соёмбо” тэмдгийг байрлуулж, дээгүүр нь хүрээлсэн хээтэй дүрсийг эргэн тойрон 4 давталттайгаар хийж, дээд ирмэг нь үргэлжилсэн түмэн наст хээн хүрээтэй, шилбэний хэсэгт резватай боогдох зориулалттай байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнийг нэг бүрчлэн ууталж, 500 ширхгээр цаасан хайрцагт савлан, давхар ярликжуулсан байна. |



50 мм
25 мм
20 мм
500 мм
390 мм
610 мм
780 мм
7 мм
27 мм
100 мм
120 мм
10 мм
11мм
5мм
10мм
7мм
5мм
17 мм
5мм
17 мм
3мм
17 мм
3мм
15 мм
90 мм
20 мм
17 мм
30 мм

# 6 ЁСЛОЛ АМРАЛТЫН СААН УНЖЛАГА

**ЗАГВАРЫН ДУГААР:** 6-40

**ХУВЦАС ӨМСӨХ ЗОРИУЛАЛТ:**
Ёслол амралтын саан унжлагыг цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нар ёслол амралтын хувцас өмссөн үед кителийн баруун мөрөнд углаж, унжлагын гогцоог энгэрийн дээд талын

товчинд товчилж хэрэглэнэ.







**МАТЕРИАЛЫН ШИНЖ ЧАНАР**

Ёслол амралтын саан унжлагыг мөнгөлөг саарал өнгийн металл саан утсаар сүлжиж хийнэ.

**Багцын дугаар-40**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэг (читон)**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нэг бүрт олгоно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдгийг төмрөөр төмрийн уусмалд бүрж, мөнгөлөг цагаан өнгөтэй болгож хийх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | “Офицер” тэмдэг 1500 ширхэг<br>“Цагдаа” тэмдэг 2500 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.09.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт тэмдэг тус бүрээс 1 ширхэг тэмдэг ирүүлнэ/ | Алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэг нь дараах загвар, хэмжээний дагуу хийгдсэн байна. Үүнд:<br><br><br>Тогтоогч шонг гантай төмрөөр тэмдгийн голд сайтар гагнаж тогтоосон байна. Тэмдэг нь нийт 42-44 гр жинтэй байна.<br>  |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Энгэрийн тэмдгийг нэг бүрчлэн уутлаж, цохих тоо хэмжээгээр нь цаасан хайрцагт савлаж, хаягжуулсан байна. |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Өвлийн хувцасны хар хөх даавуу**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нарын өвлийн хүрэм өмдний зориулалттай үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн өвлийн болон хээрийн хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0496:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар хөх /Total Eclipse, Pantone 19-4010 TPX, Color hex #192027/ өнгөтэй, 35%-ийн хөвөн, 65%-ийн полиэстерийн холиотой, 250-270 г/м$^2$ жинтэй, 0.45-0.50 мм зузаан, 3/2 ташуу нэхээстэй, нэхээсний нягт зууш 620-630, хөндлөн 225-235, бүрзийлт /7000 эргэлтэд/ 4 баллаас багагүй, агаар нэвтрүүлэлт 270-280 л/цаг-см$^2$ , 90-95 мм/сек, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4 баллаас, элэгдэл тэсвэрлэлт 50000-аас, энгийн өргөн нь 150 +/- 2см-ээс багагүй хэмжээтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж даавуу 1 метрийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй формальдегидийн хэмжээ 150 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт-17000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Өвлийн хувцасны зориулалттай хар хөх даавуу нь:<br>-ус нэвтрүүлдэггүй үзүүлэлт (15-20 удаагийн угаалтад тэсвэртэй)<br>-бактерийн эсэргүүцэлтэй (15-20 удаагийн угаалтад тэсвэртэй)<br>-хөлсийг гадагшлуулдаг (15-20 удаагийн угаалтад тэсвэртэй)<br>-будгийн тогтвор сайн байхын зэрэгцээ хэрэглээнд тэсвэртэй, хир тоос татдаггүй, үрчийдэггүй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн нэхээсний алдагдал, будгийн алаггүй, механик гэмтэлгүй байх шаардлагатай бөгөөд тус үзүүлэлтүүдийг тодорхойлсон нийлүүлэгч орны ирэх бүхий байгууллагын шинжилгээний дүгнэлтийг ирүүлсэн байна.<br><br>Хар хөх даавууны боодлын уртыг үйлдвэрлэлийн нөхцөлд материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 80-110 метрээс багагүй урттайгаар боодол болгон битүүмжилж савласан байна.<br><br>Тухайн материалыг үйлдвэрлэх газрын танилцуулга, материалын технологийн горимын дэлгэрэнгүй тодорхойлолт, үйлдвэрт мөрдөгддөг улсын болон үйлдвэрийн техникийн нөхцөл, стандартыг монгол хэлэнд хөрвүүлэн ирүүлсэн байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Хар хөх даавууг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуу уутанд хийж, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-42**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Хээрийн хувцасны хар хөх даавуу**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нарын хээрийн хүрэм, өмдний зориулалттай үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн өвлийн болон хээрийн хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0496:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар хөх /Dark Navy, Pantone 19-4013 TPX, Color hex #1b1d26/ өнгөтэй даавуу нь 35 %-ийн хөвөн, 65%-ийн полиэстерийн холиотой, 210-230 г/м$^2$ жинтэй, 0.35-0.38 мм зузаан, оруулга утастай энгийн тэгш нэхээстэй, нэхээсний нягт тууш 440-460, хөндлөн 230-240, бүрзийлт /7000 эргэлтэд/ 4 баллаас багагүй, агаар нэвтрүүлэлт 130-140 л/цаг-см$^2$ , 80-85 мм/сек, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4 баллаас, элэгдэл тэсвэрлэлт 50000-аас, энгийн өргөн нь 150 +/- 2см-ээс багагүй хэмжээтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж даавуу 1 метрийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй формальдегидийн хэмжээ 60 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт-10000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Хээрийн хувцасны зориулалттай хар хөх даавуу нь:<br>-цахилгаанжилтын эсэргүүцэлтэй<br>-ус нэвтрүүлдэггүй үзүүлэлт (20 удаагийн угаалтад тэсвэртэй)<br>-бактерийн эсэргүүцэлтэй (20 удаагийн угаалтад тэсвэртэй)<br>-хөлсийг гадагшлуулдаг (20 удаагийн угаалтад тэсвэртэй)<br>-будгийн тогтвор маш сайн байхын зэрэгцээ хэрэглээнд тэсвэртэй, хир тоос татдаггүй, үрчийдэггүй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн нэхээсний алдагдал, будгийн алаггүй, механик гэмтэлгүй байх шаардлагатай бөгөөд тус үзүүлэлтүүдийг тодорхойлсон нийлүүлэгч орны ирэх бүхий байгууллагын шинжилгээний дүгнэлтийг ирүүлсэн байна.<br><br>Хар хөх даавууны боодлын уртыг үйлдвэрлэлийн нөхцөлд материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 80-110 метрээс багагүй урттайгаар ороож, үргэлжилсэн болон хэсэгчилсэн утасны алдагдал, гэмтэл, будгийн алаггүй 3 жилийн хугацаанд үндсэн шинж чанараа алдахгүй байх шаардлагатай.<br><br>Тухайн материалыг үйлдвэрлэх газрын танилцуулга, материалын технологийн горимын дэлгэрэнгүй тодорхойлолт, үйлдвэрт мөрдөгддөг улсын болон үйлдвэрийн техникийн нөхцөл, стандартыг монгол хэл дээр хөрвүүлэн ирүүлсэн байна.<br><br>Мөн үйлдвэрийн явцад гарсан утас, нэхээсний алдагдлын хорогдлыг хэмжээг тооцож гаргасан дагалдах баримт бичгийг ирүүлнэ. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Хар хөх даавууг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуу уутанд хийж, давхар ярлыкжуулсан байна. |

**Багцын дугаар-43**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Өдөр тутмын хувцасны хар хөх даавуу**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн ахлах, дунд офицер, ахлагч нарын өдөр тутмын хувцасны зориулалттай үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0494:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар хөх /Blue nights, Pantone 19-4023 TPX, Color hex #1b1f25/ өнгөтэй 50%-ийн ноос, 50%-ийн полиэстерийн холиотой, 250-270 г/м$^2$ жинтэй, 0.35-0.45 мм зузаан, тууш 280-290, хөндлөн 200-100-ын нягт нэхээстэй, 2/1 ташуу нэхээстэй, будгийн тогтвор угаалт, хуурай үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 балл, агаар нэвтрүүлэлт 850-860 л/цаг-см$^2$, 310-320 мм/сек, багагүй, нойтон үрэлтэд болон гэрлийн үйлчлэл, гандалт 4 баллаас багагүй, бүрзийлт /7200 эргэлтэд/ 3-4 баллаас багагүй, үрэлт тэсвэрлэлт /эргэлтийн тоо 7000/ 4 баллаас багагүй, элэгдэл тэсвэрлэлт 55000-аас багагүй, 150 см өргөнтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж даавуу 1 метрийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй формальдегидийн хэмжээ 60-70 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт-5000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Өдөр тутмын хувцасны зориулалттай хар хөх даавуу нь цахилгаанжилтын эсэргүүцэлтэй, хэрэглээнд тэсвэртэй, хир тоос татдаггүй, үрчийдэггүй, будгийн тогтвор нь угаалт, үрэлт, химි цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 баллаас багагүй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн нэхээсний алдагдал, будгийн алаггүй, механик гэмтэлгүй байх шаардлагатай.<br><br>Хар хөх ноосон даавууны боодлын уртыг үйлдвэрлэлийн нөхцөлд материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 80-110 метрээс багагүй урттайгаар боодол болгон битүүмжилж савласан байна.<br><br>Тухайн материалыг үйлдвэрлэх газрын танилцуулга, материалын технологийн горимын дэлгэрэнгүй тодорхойлолт, үйлдвэрт мөрдөгддөг улсын болон үйлдвэрийн техникийн нөхцөл, стандартыг монгол хэлэнд хөрвүүлэн ирүүлсэн байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Хар хөх даавууг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуун уутанд хийж, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-44**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Албаны цамцны цэнхэр даавуу**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нарын албаны цамцны зориулалттай үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн цамцны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0499:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цэнхэр /Provence, Pantone 17-4032 TPX, Color hex #638cc7/ өнгөтэй 35%-ийн хөвөн, 65%-ийн полиэстерийн холиотой, 120-130 г/$м^2$ жинтэй, 0.20-0.25 мм зузаан, энгийн ташуу нэхээстэй, нэхээсний нягт тууш 390-400, хөндлөн 290-300, бүрзийлт 4 баллаас багагүй, агаар нэвтрүүлэлт 850-860 л/цаг-$см^2$, 310-320 мм/сек, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 баллаас, элэгдэл тэсвэрлэлт 55000-аас, энгийн өргөн нь 150 +/- 2см-ээс багагүй хэмжээтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж даавуу 1 метрийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, формальдегидийн хэмжээ 50 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт-5000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Албаны цамцны зориулалттай цэнхэр даавуу нь тоос шороо, хог татдаггүй, агаар нэвтрүүлэлт сайтай, бактерийн эсэргүүцэлтэй, хөлсийг гадагшлуулдаг, хэрэглээнд тэсвэртэй, үрчийдэггүй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн нэхээсний алдагдал, будгийн алаггүй, механик гэмтэлгүй, будгийн тогтвор угаалт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4-5 балл байх шаардлагатай.<br><br>Албаны цамцны цэнхэр даавууны боодлын уртыг үйлдвэрлэлийн нөхцөлд материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 100 метрээс багагүй урттайгаар боодол болгон битүүмжилж савласан байна.<br><br>Тухайн материалыг үйлдвэрлэх газрын танилцуулга, материалын технологийн горимын дэлгэрэнгүй тодорхойлолт, үйлдвэрт мөрдөгддөг улсын болон үйлдвэрийн техникийн нөхцөл, стандартыг монгол хэлэнд хөрвүүлэн ирүүлсэн байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Албаны цамцны цэнхэр даавууг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуу уутанд хийж, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-45**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Өдөр тутмын цамцны хар хөх даавуу**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн дээд, ахлах, дунд офицер, ахлагч нарын өдөр тутмын цамцны үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн цамцны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0499:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар хөх /Black Iris, Pantone 19-3921 TPX, Color hex #161b2b/ өнгөтэй 60%-ийн хөвөн, 40%-ийн полиэстерийн холиотой, 180-190 г/м$^2$ жинтэй, 0.30-0.35 мм зузаан, 2х1 ташуу нэхээстэй, нэхээсний нягт тууш 550-560, хөндлөн 270-280, бүрзийлт 4 баллаас багагүй, агаар нэвтрүүлэлт 770-830 л/цаг-см$^2$, 280-330 мм/сек, будгийн тогтвор угаалт, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4 баллаас, элэгдэл тэсвэрлэлт 55000-аас, энгийн өргөн нь 150 +/- 2см-ээс багагүй хэмжээтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж даавуу 1 метрийг ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, формальдегидийн хэмжээ 50 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт-25000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Өдөр тутмын цамцны зориулалттай хар хөх даавуу нь тоос шороо, хог татдаггүй, агаар нэвтрүүлэлт сайтай, бактерийн эсэргүүцэлтэй, хөлсийг гадагшлуулдаг, хэрэглээнд тэсвэртэй, үрчийдэггүй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн нэхээсний алдагдал, будгийн алаггүй, механик гэмтэлгүй, будгийн тогтвор угаалт, хими цэвэрлэгээ, гэрэл, хөлс, савангийн үйлчлэлд 4 балл байх шаардлагатай.<br><br>Өдөр тутмын цамцны хар хөх даавууны боодлын уртыг үйлдвэрлэлийн нөхцөлд материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 100 метрээс багагүй урттайгаар боодол болгон битүүмжилж савласан байна.<br><br>Тухайн материалыг үйлдвэрлэх газрын танилцуулга, материалын технологийн горимын дэлгэрэнгүй тодорхойлолт, үйлдвэрт мөрдөгддөг улсын болон үйлдвэрийн техникийн нөхцөл, стандартыг монгол хэлэнд хөрвүүлэн ирүүлсэн байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Өдөр тутмын цамцны хар хөх даавууг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуу уутанд хийж, давхар ярликжуулсан байна. |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Дулаалгын материал /тенсулейт/**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагчдын өвлийн хүрэм өмдний дулаалгын зориулалттай материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн өвлийн болон хээрийн хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0496:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цагаан өнгөтэй, дулаалгын зориулалттай 250, 400 г/$м^2$ жинтэй, агаар нэвтрүүлэлт, дулаан хадгалах чадвар сайтай, угаалт, элээлтэд тэсвэртэй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн жингийн алдагдалгүй, механик гэмтэлгүй энгийн өргөн 160 +/- 2,5 см-ээс багагүй хэмжээтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж 400 грамм жинтэй тенсулейт 1 метр, 250 грамм жинтэй тенсулейт 1 метрийг ирүүлнэ/ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүй байдал | Хүний биеийг гадны таагүй нөхцөлөөс бүрэн хамгаалж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 250 грамм жинтэй тенсулейт -12000 метр<br>400 грамм жинтэй тенсулейт -7000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Өвлийн хүрэм, өмдний дулаалгын зориулалттай 250, 400 грамmтай тенсулейт нь агаар нэвтрүүлэлт, дулаан хадгалах чадвар сайтай, угаалт, элээлтэд тэсвэртэй, хэсэгчилсэн болон үргэлжилсэн жингийн алдагдалгүй, механик гэмтэлгүй байх шаардлагатай.<br><br>Дулаалгын 250, 400 граммтай тенсулейтийг үйлдвэрлэлийн материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 25 метрээр ороож боодол болгон битүүмжилж савласан байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Дулаалгын тенсулейтийг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуу уутанд хийж, давхар ярликжуулсан байна |

**Багцын дугаар-47**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Өвлийн өмдний дотор даавуу**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагчдын өвлийн өмдийг доторлох зориулалттай материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Цагдаагийн алба хаагчийн өвлийн болон хээрийн хувцасны материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0496:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Хар өнгөтэй 100% -ийн хөвөнгийн холиотой, 1$м^2$-ын жин нь 135-150 г/$м^2$, энгийн тэгш нэхээстэй, бүрзийлт 7200 эргэлтэд 3-4 баллаас багагүй, элэгдэл тэсвэрлэлт 40000 эргэлтийн тооноос багагүй, будгийн тогтвор угаалт, хөлс, үрэлт, хими цэвэрлэгээ, гэрэл, индүүлэг, савангийн үйлчлэлд 3-4 баллаас багагүй, энгийн өргөн 110 +/- 2,5 см-ээс багагүй хэмжээтэй байна.<br><br>/Материалын бүтэц, шинж чанарын үзүүлэлтийг гаргасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлт, буцаан олгогдохгүй дээж даавуу 1 метрийг тус тус ирүүлнэ./ |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй, формальдегидийн хэмжээ 50 мг/кг-аас ихгүй, pH 4.8-7.5 байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Нийт-11000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.07.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Өвлийн өмдний доторлогооны хар даавуу нь үсэрхэг гадаргуутай , агаар нэвтрүүлэлт сайтай, хэрэглээнд тэсвэртэй, тоос шороо татдаггүй, дулаан хадгалах чадвар сайтай, хэсэгчилсэн болон үргэлжилсэн нэхээсний алдагдал, будгийн алаггүй, механик гэмтэлгүй байх шаардлагатай.<br><br>Өмдний дотрын үсэрхэг гадаргуутай даавууг үйлдвэрлэлийн нөхцөлд материал зарцуулалтад хэмнэлттэй, үлгэр дундын болон татлагын үлдэгдэл багатай байх нөхцөлийг хангасан байхаар 60-70 метрээс багагүй урттайгаар боодол болгон битүүмжилж савласан байна.<br><br>Тухайн материалыг үйлдвэрлэх газрын танилцуулга, материалын технологийн горимын дэлгэрэнгүй тодорхойлолт, үйлдвэрт мөрдөгддөг улсын болон үйлдвэрийн техникийн нөхцөл, стандартыг монгол хэлэнд хөрвүүлэн ирүүлсэн байна. |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Өвлийн өмдний дотрын даавууг тээвэрлэхэд тохиромжтой байдлаар энгийн өргөний дагуу толгой болгон ороож, нэг бүрчлэн гялгар уутаар бүрж, цэвэр бохир жин, артикул, энгийн, өргөн, уртын хэмжээг бичсэн үйлдвэрлэлийн тодотголтой шошгыг зүүсэн байна. Гадуур нь тааран болон ямбуу уутанд хийж, давхар ярликжуулсан байна. |

**Багцын дугаар-48**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Саан тууз**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт ёслол жагсаалын үед ёслолын хувцастай хэрэглэх ёслолын саан мөрдэс болон саан бүсний зориулалттай үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 5-12 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн мөрдэсний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0502:2021 дугаартай байгууллагын стандарт, техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Цагдаагийн алба хаагчийн ёслолын саан мөрдэс, саан бүсний тууз нь мөнгөлөг цагаан /Silver pantone 14-5002 TPX Color hex #b2b4b4/ өнгөтэй, төмрийн орц нь 50 хувиас багагүй хэмжээтэй тууз байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | Ёслолын бүсний саан тууз 1000 метр<br>Ёслолын мөрдэсний саан тууз 2000 метр |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.06.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа<br><br>/Загварт 1 метр дээж ирүүлнэ/ | Цагдаагийн алба хаагчийн ёслолын мөрдэсний зориулалттай саан тууз нь мөнгөлөг цагаан өнгөтэй, 4,5 см-ийн өргөнтэй, 2 талын захын ирмэгээр 1 см-ийн өргөнтэй үргэлжилсэн алхан хээн хүрээтэй, төмөр саан туузан материал байна.<br><br>Цагдаагийн алба хаагчийн ёслолын бүсний зориулалттай саан тууз нь мөнгөлөг цагаан өнгөтэй, 5,0 см-ийн өргөнтэй, 2 ирмэгээрээ 1 см-ийн өргөнтэй үргэлжилсэн алхан хээн хүрээтэй, төмөр саан туузан материал байна.<br><br>Саан туузны хүрээний алхан хээ нь жигд тод, товойлгож нэхэгдсэн байхын зэрэгцээ нь тууз нь бүхэлдээ нэхээсний алдагдалгүй цэвэр, үзэмжтэй, бөх бат хийгдсэн байх шаардлагатай.<br><br> |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнийг 50-70 метрээр уртын дагуу ороож гялгар уутанд савлан, давхар ярликжуулсан байна. |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Бүтээгдэхүүний нэр: Ёслолын бүсний арал /шонхортой/**

| | Агуулга | Дэлгэрэнгүй тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | Барааны зориулалт | Цагдаагийн алба хаагч нэг бүрт ёслол жагсаалын үед ёслол албаны хувцсан дээр бүслэх бүсний үндсэн материал болно. |
| 2 | Мөрдөх чанар, стандартын шаардлага | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 155 дугаар тогтоолоор батлагдсан 5-12 дугаар загвар, Цагдаагийн алба хаагчийн бүсний материалд тавигдах техникийн шаардлага CS 11-0501:2021 дугаартай байгууллагын стандарт техникийн тодорхойлолт, технологи ажиллагааны шаардлагыг хангасан байна. |
| 3 | Бүтэц: Шинж чанар | Мөнгөлөг цагаан өнгөтэй металлаар хийсэн байх бөгөөд эдэлгээний шаардлагыг бүрэн хангасан байна. |
| 4 | Эрүүл ахуй, аюулгүйн байдал | Хүний биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэггүй байх шаардлагатай. |
| 5 | Хэрэгцээтэй тоо, ширхэг | 4100 ширхэг |
| 6 | Нийлүүлэх хугацаа | 2024.03.25-аас 2024.06.01 |
| 7 | Үйлдвэрлэх технологи ажиллагаа | Цагдаагийн алба хаагчдын ёслолын бүсний арал нь 6:7 см тольтой, толийг голуулан 4,5 см диаметртэй “Цагдаа” бэлгэдэл тэмдгийг батлагдсан загвар, стандартын дагуу өөрөөс нь товойлгон хийж гүйцэтгэсэн байх бөгөөд 160.3 грамм жинтэй байна.<br>Цагдаагийн алба хаагчийн ёслолын саан бүсний арал нь хэрэглээнд тэсвэртэй байх шаардлагатай.<br><br> |
| 8 | Баглаа боодол, барааны нэр, шошго | Бэлэн бүтээгдэхүүнийг иж бүрдүүлэн багцлан ууталж, 500 ширхгээр цаасан хайрцагт савлан, давхар ярликжуулсан байна. |

## Бараа нийлүүлэлтийн хуваарь

*[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө ]*

| Багцын дугаар | Барааны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Өгөгдлийн хүснэгтэд заасан барааг хүргэх эцсийн цэг | Бараа нийлүүлэх хугацаа | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа *(Оролцогч энэ баганыг бөглөнө)* |
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* |
| **Нэг. Дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой бараанууд** | | | | | | |
| 1 | Албаны саравчтай малгай (хар хөх өнгөтэй) | 3780 | ширхэг | Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | Албаны саравчтай малгай (цагаан өнгөтэй) | 350 | | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 2 | Каракуль малгай | 53 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.12.25 | |
| 3 | Өвлийн малгай (хиймэл үстэй) | 1600 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| | | 1730 | | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 4 | Өвлийн малгай (хиймэл үстэй) | 1600 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| | | 1800 | | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 5 | Албаны китель, өмд | 1100 | хос | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| | Албаны китель, юбка | 100 | | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| 6 | Өдөр тутмын хүрэм, өмд | 333 | хос | | 2024.03.25-аас 2024.05.01 | |
| | | 1317 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 7 | Каракуль захтай савхин хүрэм | 31 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.12.25 | |
| | Савхин хүрэм (эрэгтэй) | 630 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.05.01 | |
| | | 2300 | | | 2024.03.25-аас 2024.08.01 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Савхин хүрэм (эрэгтэй) | 650 | ширхэг | Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв | 2024.03.25-аас 2024.05.01 | |
| | | 1800 | | | 2024.03.25-аас 2024.08.01 | |
| | Савхин хүрэм (эмэгтэй) | 100 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.05.01 | |
| | | 380 | | | 2024.03.25-аас 2024.08.01 | |
| 9 | Каракуль захтай өвлийн хүрэм, өмд | 185 | хос | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| | Хиймэл үсэн захтай өвлийн хүрэм, өмд | 1200 | хос | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| | | 1000 | | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 10 | Хиймэл үсэн захтай өвлийн хүрэм, өмд | 1300 | хос | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| | | 1000 | | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 11 | Хээрийн хүрэм, өмд | 750 | хос | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| | | 1000 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 12 | Хээрийн хүрэм, өмд | 750 | хос | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| | | 1000 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 13 | Борооны цув | 1500 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 3300 | | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 14 | Ёслолын цамц (богино ханцуйтай) | 3500 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.06.20 | |
| 15 | Албаны цамц (богино ханцуйтай) | 5000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.06.20 | |
| 16 | Өдөр тутмын цамц (урт ханцуйтай) | 5100 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 17 | Өдөр тутмын цамц (урт ханцуйтай) | 5143 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.10.01 | |
| 18 | Ноосон цамц | 2000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 3900 | | | 2024.03.25-аас 2024.10.01 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | Өвлийн оймстой гутал | 3600 | хос | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 20 | Богино түрийтэй гутал | 2000 | хос | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| | | 3000 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 21 | Пүүзэн ботинк | 4000 | хос | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 4000 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 22 | Ёслолын саан бүс | 3500 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 23 | Ёслолын саан бүс | 1000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 2000 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| | Ёслолын саан мөрдэс | 2500 | хос | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 24 | Албаны мөрдэс | 14000 | хос | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 25 | Тэлээ | 1600 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 26 | Зангиа (эрэгтэй) | 8000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 27 | Ханцуйн бэлгэдэл тэмдэг (зангуутай) | 10000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | Ханцуйн бэлгэдэл тэмдэг (зангуугүй) | 4000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| **Хоёр. Дотооддоо үйлдвэрлэх боломжгүй бараанууд** | | | | | | |
| 28 | Берет малгай | 5000 | ширхэг | Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 29 | Албаны хүрэм | 5377 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.08.01 | |
| | | 5000 | | | 2024.03.25-аас 2024.09.30 | |
| 30 | Гэрэлтүүлэгчтэй хантааз (зуны) | 1400 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.05.01 | |
| | | 4000 | | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 6000 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 31 | Гэрэлтүүлэгчтэй хантааз (өвлийн) | 700 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.04.25 | |
| | | 4300 | | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 6400 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 32 | Хүзүүвч | 8400 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.09.01 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 33 | Дан өмд | 10437 | ширхэг | Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 34 | Тоногтой бүс | 5800 | иж бүрдэл | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 35 | Цамцны мөрдэс | 20000 | хос | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 36 | Цолны тэмдэг | 80000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 37 | Ёслолын малгайн тэмдэг | 2000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | Өдөр тутмын малгайн тэмдэг | 3000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| | Захны таних тэмдэг | 6000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 38 | Зангианы хавчаар | 4500 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | Ёслолын бээлий | 2560 | хос | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 39 | Ёслолын саан унжлага | 4000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | | 4850 | | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 40 | Алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэг (читон) | 4000 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.09.01 | |
| 41 | Өвлийн хувцасны хар хөх даавуу | 17000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 42 | Хээрийн хувцасны хар хөх даавуу | 10000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 43 | Өдөр тутмын хувцасны хар хөх даавуу | 5000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 44 | Албаны цамцны цэнхэр даавуу | 5000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 45 | Өдөр тутмын цамцны хар хөх даавуу | 25000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 46 | Дулаалгын материал (250 гр/м2 жинтэй) | 12000 | метр | Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| | Дулаалгын материал (400 гр/м2 жинтэй) | 7000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 47 | Өмдний дотор даавуу | 11000 | метр | | 2024.03.25-аас 2024.07.01 | |
| 48 | Ёслолын бүсний саан тууз | 10000 | метр | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| | Ёслолын мөрдэсний саан тууз | 2000 | метр | | 2024.03.25-аас 2024.06.01 | |
| 49 | Ёслолын бүсний арал | 4100 | ширхэг | | 2024.03.25-аас 2024.06.01 | |

-oOo-

## IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### IV.1.“Чанар ба үнийн хосолмол” тендер үнэлэх үндсэн шалгуур

1. *Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах чанар ба үнийн хосолмол шалгуур* ***(Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтаас бусад тендер шалгаруулалтад тус тендер үнэлэх үндсэн шалгуурыг тендер шалгаруулалтын баримт бичгээс хасна)***

   1. *Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалтын үед хамгийн бага харьцуулах үнэ (Pmin)-тэй тендерт 30 оноо (Smax) өгч, бусад оролцогчийн харьцуулах үнэ ($P_x$)-д харгалзах оноог дараах томьёогоор бодно.*

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

$P_{min}$–*Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн үнэ*
$P_x$ – *Тухайн оролцогчийн үнэ*
$S_x$ – *Тухайн оролцогчийн оноо*
$S_{max}$ –*Хамгийн бага харьцуулах үнэтэй оролцогчийн оноо*

2. ***Эмийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:***

| | | |
|---|---|---|
| 2.1. | *Эм нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:* | *8 оноо* |
| 2.2. | *ДЭМБ-ын эмийн зохицуулалтын төлөвшлийн түвшингээр 4-т жагссан улсад үйлдвэрлэгдсэн бол* | *8 оноо* |
| 2.3. | *Эм нь хатуу зохицуулалттай улсад үйлдвэрлэгдсэн бол (SRA, PICS):* | *8 оноо* |
| 2.4. | *Импортын эм нь үйлдвэрлэгч улсад хэрэглэдэг бол (чөлөөт худалдааны гэрчилгээ)* | *6 оноо* |
| 2.5. | *Ерөнхий нэршлийн эмийн хувьд биоэквивалент чанарын судалгааг хөндлөнгийн эрх бүхий судалгааны байгууллагаар хийлгэсэн бол (Цусан дахь эмийн идэвхт бодисын хамгийн их концентраци (Cmax) 80 -125%)* | *6 оноо* |
| 2.6. | *Үйлдвэрлэгч нь ДЭМБ-ын эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP) хангасан гэрчилгээтэй бол* | *6 оноо* |
| 2.7. | *Эм нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамрагдсан бол* | *4 оноо* |
| 2.8. | *Эм нь Англи, АНУ, Европ, Япон, БНХАУ, ОХУ-ын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол* | *4 оноо* |
| 2.9. | *Эм нь АНУ-ын бүртгэлтэй эмийн жагсаалт “Orange Book”-д орсон бол* | *4 оноо* |
| 2.10. | *Эм нь ДЭМБ-ын харьцуулах бүтээгдэхүүний жагсаалтад орсон бол* | *4 оноо* |
| 2.11. | *Анхдагч буюу оригинал эм бол* | *4 оноо* |

2.12. *Ханган нийлүүлэгч нь өөрөө импортлогч бол* 4 оноо

2.13. *Тухайн эм нь сүүлийн нэг жилд лабораторийн шинжилгээгээр стандарт бус гараагүй бол* 2 оноо

2.14. *Эмийн аюулгүй байдлын хугацаат тайланг (PSUR) сүүлийн 2 жилийн хугацаанд эмийн зохицуулалтын байгууллагад мэдээлсэн бол* 2 оноо

*Нийт 70 оноо*

***3. Эмийн чанарын үнэлгээг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ:***

3.1. *Үйлдвэрлэгч нь ISO 13485 стандартын шаардлага хангасан бол* 15 оноо

3.2. *Импортын эмнэлгийн хэрэгсэл нь үйлдвэрлэгч улсдаа хэрэглэдэг бол (FREE SALE CERTIFICATE)* 15 оноо

3.3. *Эмнэлгийн хэрэгсэл нь гурав ба түүнээс дээш улсад нийлүүлэгддэг бол* 15 оноо

3.4. *Үйлдвэрлэгч нь үйлдвэрлэлийн сайн дадал (Good manufacturing practice) гэрчилгээтэй бол* 15 оноо

3.5. *Үйлдвэрлэгч нь ISO 9001 стандартын шаардлага хангасан бол* 10 оноо

*Нийт 70*

4. *Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурт нийт оноог дээрх аргачлалын дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ.*

$$B_x = Q_x + S_x$$

*Bx – Тухайн оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо*

*Qx – Тухайн оролцогчийн чанарын үнэлгээний оноо*

## IV.2.Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 29.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. *Бараа хүргэх, ажил, үйлчилгээ дуусгах хугацаа:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]***

   *Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний*

*үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.*

*Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд* ***[хувь бичих]****–аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.*

*Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас* ***[тоо бичих]****-аас илүү* ***[“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]*** *хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. *Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

   *Хэрэв “ашиглах” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.*

3. *Байгаль орчинд нөлөөлөх байдал:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

   *Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ.* ***[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

4. *Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

   *Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ.* ***[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

   *Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах үнийг дараах байдлаар тодорхойлж болно.*

*Жишээ нь: А4 бичгийн цаас худалдан авах үнэлгээний шалгуур үзүүлэлт*

| № | Шалгуур үзүүлэлт | Үнэлгээ |
|---|---|---|
| ***I*** | ***Нийгмийн шалгуур*** | ***Хамгийн их оноо (-5%)*** |
| *1.1* | *Олон улсын хөдөлмөрийн стандарт, ОУХБ-ын Суурь конвенцыг дагаж мөрдөж буй байдал* | |
| *1.2* | *Ажиллах хүч / ажил эрхлэлтийн харилцаа* | |
| *1.3* | *Ажиллагсдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгал* | |
| *1.4* | *Шударга цалин хөлс болон хөдөлмөрийн харилцаа* | |
| *1.5* | *Ажиллах орчны аюулгүй байдал* | |
| *1.6* | *Нийгмээс тусгаарлагдсан хүмүүсийн ажил эрхлэлт* | |
| ***II*** | ***Эдийн засгийн шалгуур*** | ***Хамгийн их оноо (-5%)*** |
| *2.1* | *Бизнесийн ёс зүй (Ёс зүйн код)* | |
| *2.2* | *Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дэмжлэг* | |
| *2.3* | *Тээвэрлэлт/хүргэлт* | |
| *2.4* | *Хаяж устгах (Биетээр татан авах эсвэл аюулгүй байдлаар устгах)* | |
| ***III*** | ***Байгаль орчны тогтвортой байдлын шалгуур*** | ***Хамгийн их оноо (-10%)*** |
| *3.1* | *Байгаль орчны хууль тогтоомж дагаж мөрдөж буй байдал (ISO 14001)* | |
| *3.2* | *Компанийн чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001)* | |
| *3.3* | *Таримал ойгоос бэлтгэсэн, эсхүл дахин боловсруулсан цаас* | |
| *3.4* | *Энгийн хлор агуулаагүй* | |
| *3.5* | *Цайралт* | |
| *3.6* | *Байгаль орчинд ээлтэй савлагаа* | |
| *3.7* | *Дахин боловсруулах боломжтой* | |

*Дээрх үнэлгээний шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тендерт оролцогчийн санал болгож буй үнийг (-20) хувь хүртэл нэмэгдүүлж харьцуулах үнийг тодорхойлно. Уг үнэ нь зөвхөн харьцуулах зорилготой. Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлтийн талаар Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааны гарын авлага (МУСЯ, НҮББОХ, 2018)-аас танилцах боломжтой.*

# V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Маягт 1.Тендер илгээх маягт

Маягт 2.Барааны үнийн задаргаа

Маягт 3.Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 5.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 6.Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1 **Тендер илгээх маягт**

***[огноо]***

***[Захиалагч байгууллагын нэр]***-д

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "**тендер**" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:

   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;

   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;

   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;

   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ***["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[30 ба түүнээс дээш хоногийн тоо]*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.[1]
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[1] Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "*5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.*" гэж сольж бичнэ үү.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***

***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***

***албан тушаал, гарын үсэг,***

***байгууллагын тамга, тэмдэг]:***

***Хаяг:***

Маягт 2 **Барааны үнийн задаргаа**

| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* | *7* | *8* | *9* | *10* | *11* |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Барааны нэр** | **Гарал үүслийн улс**[2] | **Тоо хэмжээ** | **Хэмжих нэгж, тун** | **Нэгж үнэ** | **Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4х6)** | **Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ** | **Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж** | **Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9)** | **Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх**[3] |
| 1 | | | | | | | | | | *Тийм/Үгүй* |
| 2 | | | | | | | | | | |
| ... | | | | | | | | | | |
| | **Тендерийн нийт үнэ** | | | | | | | | | |

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,***
***эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,***
***албан тушаал, гарын үсэг, байгууллагын***
***тамга, тэмдэг]:***

[2] ТШЗ-ны 18.6.2-ын дагуу ирүүлсэн баримт бичигт дурдсан барааны гарал үүслийн талаарх мэдээлэлтэй ижил байна.
[3] Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх гэдэгт “тийм” гэж бөглөсөн бол түүнийг нотлох баримт бичгийг хавсаргана.

Маягт 3 **Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 4 **Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл**

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Маягт 5 **Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл**

| |
|---|
| Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].* |

| | |
|---|---|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил |
| | Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br>□Үндсэн нийлүүлэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч |

Маягт 6 **Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт**

| | **Нууцалсан баримт бичиг, мэдээлэл** | **Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл** |
|---|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

# VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

**Санамж**

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;

1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;

1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;

1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т заасначаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.

1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;

1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;

1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;

1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

## ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ

Бараа нийлүүлэх

2.1 Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

2.2 Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4 Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

**Бараа нийлүүлэх газар**

2.5 Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.

**Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах**

2.6 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.

2.7 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

2.7.1 Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.7.2 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.8 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.

2.9 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.

**Барааг хүлээлгэн өгөх**

2.10 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

2.11 Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.

**Барааны гарал үүслийн улс**

2.12 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.

2.13 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.

**Баглаа боодол**

2.14 Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.

2.15 Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

2.16 Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.

Худалдааны нөхцөл

2.17 Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.

2.18 ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.

Гүйцэтгэлийн баталгаа

2.19 Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Нийлүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Нийлүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

2.20 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

2.20.1 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

2.20.2 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.20.3 Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

2.21 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

2.22 ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

2.23 Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

## ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Барааг хүлээн авах

3.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

Шалгалт, туршилт

3.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.

3.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

3.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

## ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх эрсдэл

4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:

4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

Даатгал

4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын

гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

Доголдол

4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.

4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.

4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.

4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.

4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

Чанарын баталгаа

4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.

4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.

4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.

4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.

4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.

4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.

Алданги

4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа

хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.

Оюуны өмчийн эрх зөрчих

4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал

4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.

Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа

4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

## ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;

5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

5.1.4. Нийлүүлэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.

5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига өгсөн, залилах гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.

5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл

5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

**ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ**

Төлөөлөгч

6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.

6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.

6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

Туслан гүйцэтгэгч

6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.

6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.

Нууцлал

6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал

зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.

6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.

**Мэдэгдэл**

6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууд406анд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

**Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:

6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;

6.15.2. үнийн тохируулга хийсэн.

6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

**Маргаан шийдвэрлэх**

6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| **ГЕН 2.5.** | Бараа нийлүүлэх газар**:** ***Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 10-р хороо, Амгалан дахь Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв***. |
| **ГЕН 2.6.** | Бараа нийлүүлэх хугацаа: 2024.04.15-2024.12.25.<br><br>*Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа:* ***Цагдаагийн алба хаагчдын 2024 оны хэрэгцээнд худалдан авах дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материалыг энэ тендерийн баримт бичгийн III бүлгийн "Бараа нийлүүлэлтийн хуваарь"-т заасан хугацааны дотор нийлүүлэх.*** |
| **ГЕН 2.10.** | Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:<br><br>Бараа бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг тулган шалгаж, хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлыг Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн хувцасны чанар, технологийн мэргэжилтэн нарын гаргасан барааг татуулах тухай танилцуулга, чанарын дүгнэлт болон худалдан авагчийн зөвшөөрлийн бичгийг тухай бүрт нь үндэслэл болгон Хангалт, үйлчилгээний төвийн хувцасны ахлах мэргэжилтэнээр ахлуулсан комисс, бэлтгэн нийлүүлэгчийн төлөөлөгчид байлцан хууль тогтоомжид заасан журмын дагуу хүлээн авч, холбогдох акт, нотломжийг үйлдэн баталгаажуулна.<br>Бараанд холбогдох баримт бичиг:<br><br>• Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;<br>• Худалдан авагчтай байгуулсан гэрээ;<br>• Барааны загвар, техникийн тодорхойлолт;<br>• Гүйцэтгэлийн баталгаа (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасны дагуу санхүүжих дүнгийн 3 хувиар 42.3-т заасан хэлбэрээр гаргаж ирүүлсэн баталгаа);<br>• Урьдчилгаа төлбөрийн баталгаа (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.4-т заасны дагуу 43.5-д заасан хэлбэрээр гаргаж ирүүлсэн баталгаа);<br>• Барааг бөөнөөр үйлдвэрлэх зөвшөөрөл;<br>• Барааг (худалдан авагчийн агуулах)-ад татуулах тухай танилцуулга, холбогдох чанарын дүгнэлт, шийдвэр;<br>• Худалдан авагчаас олгосон материалын зардлыг тооцож үнэлгээ хийсэн акт;<br>• Бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын баримт;<br>• Худалдан авагчийн орлогын баримт;<br>• Барааг хүлээн авсан тухай акт;<br>• Тооцооны үлдэгдлийн баталгаа;<br>• Гэрээний хэрэгжилтийн явцад 2 талын харилцсан албан бичиг, холбогдох шийдвэртэй холбоотой баримт бичиг;<br>• Татварын цахим системд тус албаны регистр (6882889)-ээр үүсгэсэн цахим нэхэмжлэл;<br>• Өглөг, авлагын дэлгэрэнгүй журнал;<br>• Гэрээ дүгнэсэн маягт г.м болно.<br><br>Угсралт, суурилуулах: "Үгүй" |

| | |
|---|---|
| **ГЕН 2.14.** | Баглаа, боодол: Цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материал нь зориулалтын сав баглаа, боодолтойгоор гадны нөлөөллөөс бүрэн хамгаалагдсан байна. Үүнд:<br><br>**а) Бүх төрлийн малгай**<br><br>-Албаны саравчтай малгай, каракуль бололн өвлийн малгай, берет малгайнд үйлдвэрлэгчийн тодотголтой цаасан шошгыг зүүж, нэг бүрчлэн ууталж, загвар, нэр төрөл, өмсгөл хэмжээгээр нь төрөлжүүлэн зохих тоо, хэмжээгээр цаасан хайрцагт савлаж, гадна талд нь үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо, тоо хэмжээ, размерийг тодотгож бичсэн байна.<br><br>**б) Бүх төрлийн дүрэмт хувцас**<br><br>-Албаны китель, өмд (юбка), каракуль захтай савхин хүрэм, савхин хүрэм (эрэгтэй, эмэгтэй) зэрэгт үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг зүүж, нэг бүрчлэн зориулалтын өлгүүрт өлгөн ууталж нийлүүлнэ.<br><br>-Өдөр тутмын, өвлийн, хээрийн хүрэм өмд, савхин хүрэм, борооны цуванд үйлдвэрлэгчийн тодотголтой цаасан шошгыг зүүж, нэг бүрчлэн ууталж, загвар, өмсгөл хэмжээ, нэр төрлөөр нь төрөлжүүлэн зохих тоо, хэмжээгээр багцлан боосон байна.<br><br>-Албаны хүрэм, дан өмд, гэрэлтүүлэгчтэй хантааз (өвөл, зуны), хүзүүвч, ёслолын, албаны, өдөр тутмын цамц, ноосон цамц зэрэгт үйлдвэрлэгчийн тодотголтой цаасан шошгыг зүүж, нэг бүрчлэн ууталж, загвар, нэр төрөл, өмсгөл хэмжээгээр нь төрөлжүүлэн зохих тоо, хэмжээгээр цаасан хайрцагт савлаж, түүний гадна талд нь үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо, тоо хэмжээ, размерыг тодотгож бичсэн байна.<br><br>**в) Бүх төрлийн гутал**<br><br>-Өвлийн оймстой гутал, богино түрийтэй гутал зэргийг нэг бүрчлэн хослуулан холбож, загвар, нэр төрөл, өмсгөл хэмжээгээр нь төрөлжүүлэн зохих тоо, хэмжээгээр цаасан хайрцагт савлаж, түүний гадна талд нь үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо, тоо хэмжээ, размерыг тодотгож бичсэн байна.<br><br>-Пүүзэн ботинкыг нэг бүрчлэн ууталж, өмсгөл хэмжээ, нэр төрлөөр нь төрөлжүүлэн зохих тоо, хэмжээгээр цаасан хайрцагт давхар савлаж, түүний гадна талд нь үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо, тоо хэмжээ, размерыг тодотгож бичсэн байна.<br><br>**г) Бүс, тэлээ**<br><br>-Ёслолын саан бүс, тэлээнд үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг зүүж, нэг бүрчлэн уутлаж, рамераар нь төрөлжүүлэн багцалж, зохих тоо хэмжээгээр цаасан хайрцагт савалсан байна.<br><br>-Тоногтой бүс болон тоноглолд үйлдвэрлэгчийн тодотголтой шошгыг зүүж, нэг бүрчлэн ууталж, зохих тоо хэмжээгээр цаасан хайрцагт савлаж, түүний гадна талд нь үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо, тоо хэмжээ, размерыг тодотгож бичсэн байна.<br><br>**д) Бүх төрлийн мөрдэс** |

| | |
|---|---|
| | -Ёслолын, албаны, цамцны мөрдэс нэг бүрийг хослуулан ууталж, загвар, цолны ангилал, нэр төрлөөр нь төрөлжүүлэн зохих тоо, хэмжээгээр багцлан давхар ууталж, зохих тоо хэмжээгээр цаасан хайрцагт савласан байна.<br><br>**е) Ялгах тэмдэг**<br><br>-Цагдаагийн алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэг, ёслолын болон өдөр тутмын малгайн тэмдгийг нэг бүрчлэн ууталж, зохих тоо хэмжээгээр цаасан хайрцагт давхар савласан байна.<br><br>-Цолны тэмдэг, захны таних тэмдгийг нэг бүрчлэн ууталж, нэр төрлөөр нь төрөлжүүлэн 200-500 ширхгээр ууталж, зохих тоо хэмжээгээр цаасан хайрцагт давхар савласан байна.<br><br>-Ёслолын бүсний арлыг 6 ширхгээр багцлан боож, зохих тоо хэмжээгээр цаасан хайрцганд савласан байна.<br><br>-Ханцуйн бэлгэдэл тэмдгийг загвар, нэр төрлөөр нь төрөлжүүлэн 20 ширхгээр багцлан ууталж, зохих тоо, хэмжээгээр цаасан савласан байна.<br><br>**ё) Дүрэмт хувцасны үндсэн болон туслах материал**<br><br>-Цагдаагийн алба хаагчийн өвлийн, хээрийн, өдөр тутмын хувцасны даавуу, албаны болон өдөр тутмын цамцны даавуу, өмдний дотор даавуу, дулаалгын материалыг материалыг энгийн өргөний дагуу боодол болгон ороож, хорхой шавж, ус чийг, тоосноос хамгаалсан зориулалтын материалаар битүүмжлэн ороож, давхар даавуун уутанд савлаж, түүний гадна талд үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо, метрийн хэмжээг тодотгож бичсэн байна.<br><br>*Баглаа, боодлын шаардлага:* Цагдаагийн алба хаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг болон түүний материалыг ус, чийг. тоосноос хамгаалсан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. |
| **ГЕН 2.17.** | Худалдааны нөхцөл:<br><br>Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан (Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төв)-д хүргүүлнэ. |
| **ГЕН 3.8.** | Үнийн тохируулга хийх аргачлал: ***: "Тохируулга хийхгүй"*** |
| **ГЕН 3.9.** | Төлбөр төлөх хугацаа: 2024.03.25-2024.12.25.<br><br>Тендерт шалгарсан хуулийн этгээд (аж ахуйн нэгж, байгууллага, иргэн) нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт хийгдсэн 10,000,00.00 (Арван сая) төгрөгөөс дээш үнийн дүнтэй мөнгөн гүйлгээний талаарх мэдээллийг тухай бүрд нь шилэн дансанд байршуулж мэдээлнэ.<br><br>Төлбөрийг хэсэгчилсэн төлөх тохиолдолд төлбөр төлөх үе шатны хугацаа:<br><br>✓ ***Тендерт шалгарсан тохиолдолд байгуулсан гэрээний эрх зүйгээр зохицуулагдана.*** |
| | Захиалагч нь барааны төлбөрийг дараах журмын дагуу хийнэ.Үүнд:<br><br>а) Захиалагч нь гэрээг батлагдсанаас хойш ажлын бэлтгэл хангахад зориулан гэрээний үнийн дүнгийн 30 хүртэлх хувийн урьдчилгаа төлбөрийг бэлтгэн нийлүүлэгчээс гаргаж ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг |

| | |
|---|---|
| | үндэслэн мөн хэмжээний мөнгөн дүнтэй тэнцэх төлбөрийг бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр хийх дансаар шилжүүлнэ. Хэрэв бэлтгэн нийлүүлэгч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлээгүй тохиолдолд гэрээний хэрэгжилтийн явцад 2-3 удаагийн гүйцэтгэлд ногдох төлбөрийг бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр хийх дансаар шилжүүлж болно.<br><br>б) Эцсийн үлдэгдэл төлбөрийг барааг Цагдаагийн ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний төвд бүрэн нийлүүлсэн нөхцөлд 2 талын баталгаажуулсан гэрээ дүгнэсэн маягтыг үндэслэн бэлтгэн нийлүүлэгч төлбөр хийх дансаар шилжүүлнэ. Гэрээ нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас он дамжин хэрэгжихээр бол урьдчилгаа төлбөрийн баталгаа шаардана. |
| **ГЕН 4.2.** | Даатгал: Бэлтгэн нийлүүлэгч тал барааг худалдан авагчийн агуулах хүртэлх бүх эрсдэл, зардал болон имдортлохтой холбоотой гаалийн бүрдүүлэлт, импортын гаалийн татвар болон холбогдох бусад зардал, даатгалыг дангаар хариуцаж, худалдан авагчид хүлээлгэн өгнө. |
| **ГЕН 4.10.** | Баталгаат хугацаа: “Заасан”<br><br>Баталгаат хугацаа нь барааг нийлүүлсэн өдрөөс хойш 1 жил (12 сар). |
| **ГЕН 4.11** | Чанарын баталгаа:<br><br>Чанарын баталгаа шаардах эсэх: ”Шаардана”<br><br>Чанарын баталгааны дүн: Гэрээний эрх зүйгээр зохицуулагдана.<br><br>***Чанарын баталгаа шаардах бол:*** Чанарын баталгаа нь барааг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 1 жил (12 сар)-ийн хугацаанд хүчинтэй байна.<br><br>Чанарын баталгааны дүн: ***Хэрэв бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, хэрэглэх үед бараа бүтээгдэхүүнд үйлдвэрлэлийн гологдол, дутагдал илэрсэн бөгөөд энэ нь чанарын баталгаат хугацааны дотор бол бэлтгэн нийлүүлэгч нь уг бараа бүтээгдэхүүний гологдол, дутагдлыг засах, солих, нөхөн олгохтой холбогдох бүх зардлыг дангаар хариуцан хохиролгүй болгоно.*** |
| **ГЕН 4.17.** | Нийлүүлэгчийн төлөх алданги:<br><br>Алданги тооцох эсэх**: *“Тийм”***<br><br>Алдангийн хувь**: Барааны н*ийлүүлэлтийн хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.05 хүртэл хувиар тогтоож алданги тооцох.*** |
| **ГЕН 4.18.** | Захиалагчийн төлөх алданги:<br><br>Алданги тооцох эсэх**: “Үгүй”**<br><br>Алдангийн хувь: |

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

***[Тендер шалгаруулалтын нэрийг бичих]*** гэрээ.
Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

.............................. хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь ***[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Нийлүүлэгч ***[Нийлүүлэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
   - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
   - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
   - 3.6. Техникийн тодорхойлолт;
   - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
   - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх-ийн нэр:
     Нэр:
     Албан тушаал:
     Ажлын утас:
     Гар утас:
     Цахим шуудан:

   - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Эцэг/эх-ийн нэр:
     Нэр:
     Албан тушаал:
     Ажлын утас:
     Гар утас:
     Цахим шуудан:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| [Албан тушаал, нэр] | [Албан тушаал, нэр] |
| [Гарын үсэг]______________ | [Гарын үсэг] _____________ |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

| | |
|---|---|
| Огноо: | ***2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр*** |
| Тендер шалгаруулалтын төрөл: | Бараа |
| Тендер шалгаруулалтын нэр: | ***“Цагдаагийн алба хаагчдын 2024 оны хэрэгцээнд худалдан авах дүрэмт хувцас, ялгах тэмдэг, материал”*** |
| Тендер шалгаруулалтын дугаар: | **ЦЕГСААА/20240102001** |
| Нийт төсөвт өртөг: | ***20,857,959,000.00 төгрөг*** |
| Тендер шалгаруулалтын арга: | Нээлттэй |

1. ***Цагдаагийн ерөнхий газар*** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: ***“Тийм”***

2.1. ***Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах боломжтой бараанд доорх багцууд хамаарна.*** Үүнд:

***Дотоодын багц №1: Албаны саравчтай малгай(хар хөх, цагаан өнгөтэй);***
***Дотоодын багц №2: Каракуль малгай;***
***Дотоодын багц №3: Өвлийн малгай (хиймэл үстэй);***
***Дотоодын багц №4: Өвлийн малгай (хиймэл үстэй);***
***Дотоодын багц №5: Албаны китель өмд, китель юбка;***
***Дотоодын багц №6: Өдөр тутмын хүрэм, өмд;***
***Дотоодын багц №7: Каракуль захтай болон эрэгтэй савхин хүрэм;***
***Дотоодын багц №8: Савхин хүрэм (эрэгтэй, эмэгтэй);***
***Дотоодын багц №9: Өвлийн хүрэм, өмд (каракуль болон хиймэл үсэн захтай);***
***Дотоодын багц №10: Өвлийн хүрэм, өмд (хиймэл үсэн захтай);***
***Дотоодын багц №11: Хээрийн хүрэм, өмд;***
***Дотоодын багц №12: Хээрийн хүрэм, өмд;***
***Дотоодын багц №13: Борооны цув;***
***Дотоодын багц №14: Ёслолын цамц (богино ханцуйтай);***
***Дотоодын багц №15: Албаны цамц (богино ханцуйтай);***
***Дотоодын багц №16: Өдөр тутмын хүрэм, өмд (урт ханцуйтай);***
***Дотоодын багц №17: Өдөр тутмын хүрэм, өмд (урт ханцуйтай);***
***Дотоодын багц №18: Ноосон цамц;***
***Дотоодын багц №19: Өвлийн оймстой гутал;***
***Дотоодын багц №20: Богино түрийтэй гутал;***
***Дотоодын багц №21: Пүүзэн ботинк;***
***Дотоодын багц №22: Ёслолын саан бүс;***
***Дотоодын багц №23: Ёслолын саан бүс, саан мөрдэс;***
***Дотоодын багц №24: Албаны мөрдэс;***
***Дотоодын багц №25: Тэлээ;***
***Дотоодын багц №26: Зангиа (эрэгтэй);***
***Дотоодын багц №27: Ханцуйн бэлгэдэл тэмдэг (зангуутай, зангуугүй).***

2.2. ***Дотооддоо үйлдвэрлэх боломжгүй бараанд доорх багцууд хамаарна.*** Үүнд:

***Багц №28: Берет малгай;***
***Багц №29: Албаны хүрэм;***
***Багц №30: Гэрэлтүүлэгчтэй хантааз (зуны);***
***Багц №31: Гэрэлтүүлэгчтэй хантааз (өвлийн);***
***Багц №32: Хүзүүвч;***

***Багц №33: Дан өмд;***
***Багц №34: Тоногтой бүс;***
***Багц №35: Цамцны мөрдөс;***
***Багц №36: Цолны тэмдэг;***
***Багц №37: Ёслолын болон өдөр тутмын малгайн тэмдэг, захны таних тэмдэг;***
***Багц №38: Зангианы хавчаар, ёслолын бээлий;***
***Багц №39: Ёслолын саан унжлага;***
***Багц №40: Алба хаагчийн хувийн дугаар бүхий энгэрийн тэмдэг (читон);***
***Багц №41: Өвлийн хувцасны хар хөх даавуу;***
***Багц №42: Хээрийн хувцасны хар хөх даавуу;***
***Багц №43: Өдөр тутмын хувцасны хар хөх даавуу;***
***Багц №44: Албаны цамцны цэнхэр даавуу;***
***Багц №45: Өдөр тутмын цамцны хар хөх даавуу;***
***Багц №46: Дулаалгын материал (тенсулейт);***
***Багц №47: Өмдний дотор даавуу;***
***Багц №48: Ёслолын бүс болон мөрдэсний саан тууз;***
***Багц №49: Ёслолын бүсний арал.***

3. Тендерийг ***(2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 09 цаг 00 минут)***–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг ***(2024 оны 03 дугаар сарын 01)****-ний өдрийн*, ***(09 цаг 30 минут)****-т* нээнэ.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: ***"Зөвшөөрөхгүй"***

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: ***"Эрхтэй"*** (Дотоодын үйлдвэрлэлээс худалдан авах боломжтой барааны 1-27 дугаар хүртэлх багцуудад хамаарахгүй болно.)

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 өдрийн хугацаанд хүчинтэй байна.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: ***"Тийм"*** Тендерийн баримт бичгийн II бүлгийн өгөгдийн хүснэгтийн ТШЗ 24.1-д заасан цахим тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлнэ.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"***

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: ***"Үгүй"***

10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: ***Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж-18, Цагдаагийн ерөнхий газрын төв байрны 6 дугаар давхар, 604 тоот өрөө.***

Утасны дугаар: ***70191057***

Цахим шуудангийн хаяг: saaa,khangamj@police.com.

-оОо-